

ХАНГАЙ ДЭЭД СУРГУУЛИЙН ТУХАЙ

Хангай дээд сургууль нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 175 тоот тушаалаар мэргэжлийн анхан шатны 4, бакалаврын түвшний 2 мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэйгөөр үүсгэн байгуулагдаж өдгөө бакалаврын 12, магистрын 2, Мэргэжлийн боловсрол олгох 9 мэргэжлээр 24 дэх жилдээ сургалт, судалгааны үйл ажиллагаа явуулж байна.

Сургууль нь дээд сургуульд тавигдах шаардлагыг хангасан тул БСШУ-ны сайдын 2008 оны 09 сарын 18-ны өдрийн 479 тоот тушаалаар дээд сургууль болон батлагдаж БМИҮЗ-ийн 2006 оны 05 сарын 26-ны өдрийн 88 тоот тогтоолоор анх удаа, 2011 оны 12 сарын 22-ны өдрийн хурлаар хоёр дахь удаагаа, БМИҮЗ-ийн 2022 оны 10 сарын 31-ний өдрийн 07 тоот тогтоолоор 3 дахь удаагаа магадлан итгэмжлэгдэж, 2013 оны 10 сарын 09-ний 52 дугаар тогтоолоор НБДАХА мэргэжлийн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлж, БШУЯ-ны 2013 оны 01 сарын 09-ний 2013/18 дугаараар Аттестатчилагдсан юм.

Сургууль нь сургалтын үйл ажиллагаа явуулах хичээлийн А, Б байр, оюутны дотуур байр, соёлын болон спорт заал, мэргэжлийн анги танхим, лаборатори, дадлагын газар, 15000 гаруй номтой номын фонд бүхий 90 суудалтай номын сантай. Багшлах бүрэлдэхүүний хувьд 30 гаруй хувь нь эрдмийн зэрэг цолтой, судалгаа, шинжилгээний арга зүй эзэмшсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай, монгол болон гадаад багш нар ажиллаж байна.

Сургууль нь дэргэдээ Хангай мэргэжлийн боловсролын сургууль, Global Vision сургалтын төв, Шидэт Хаант Улс цэцэрлэг, Арвист Хангай бүрэн дунд сургуулийг байгуулан цогцолбор сургууль хэлбэрээр ажиллаж байна.

Хангай дээд сургуулийн Эрхэм зорилго: “Дэлхийн зүг Ирээдүй өөд”.

Сургуулийн алсын хараа: Даяарчлал, мэдээллийн зуунд Монгол орны эдийн засаг нийгмийн эрэлт хэрэгцээг ханган ажиллах, Шинжлэх ухааны өргөн мэдлэгтэй, мэргэжлийн ур чадварыг сайтар эзэмшсэн ёс суртахууны өндөр соёлтой мэргэжилтэн, мэргэжилтэй ажилтан бэлтгэх нээлттэй сургууль болно.

Хангай дээд сургуулийн түүхэн замнал

- 2001 онд үүсгэн байгуулагдан
- 2006 онд магадлан итгэмжлэгдсэн
- 2011 онд Global Vision гадаад хэлний сургалтын төвийг байгуулсан
- 2011 онд НБДАХА мэргэжлээр магадлан итгэмжлэгдсэн
- 2012 онд ахисан түвшинд магадлан итгэмжлэгдсэн
- 2012 онд улсын хэмжээнд монгол улсад анх удаагаа “Гадаад хэлний сургалтын агуулга, арга зүй” семинарыг зохион байгуулсан.
- 2012 онд “Эх нутгаа хөгжүүлэх оюутан залуусыг бэлтгэх” тэтгэлэгт хөтөлбөрийг анх удаа санаачлан зохион байгуулсан

- 2013 онд БСШУСЯ-аас аттестатчилагдсан
- 2015 онд сургуулийн харьяа “Шидэт Хаант Улс” цэцэрлэг, “Арвист Хангай” бүрэн дунд сургуулийг байгуулан цогцолбор сургууль болсон
- 2015 онд Монголын хувийн их, дээд сургууль, коллежуудын холбоог байгуулсан ба Японы хувийн их, дээд сургууль, коллежуудын холбоотой гэрээ байгуулсан
- 2015 онд Боловсрол судлалын Магистрын сургалт явуулж эхэлсэн
- 2016 Оёдолчин мэргэжлийн улсын стандарт боловсруулсан
- 2017 онд Монгол Улсын шилдэг Хүмүүнлэг байгууллагаар шалгарсан
- 2018 онд Европын холбооны санхүүжилттэй АРРОВ “Монголын их, дээд сургуулиудын судалгаа, инновацыг сайжруулах нь” төсөлд амжилттай хамрагдсан
- 2020 онд Бизнесийн удирдлагын магистрын сургалт явуулж эхлэв.
- 2020 оны байдлаар БНХАУ-ын СИАС олон улсын их сургууль, Тайваний Минг Чуан их сургууль, БНЭУ-ын КИЙТ их сургууль гэх мэт олон улсын сургуулиуд болон хамтын ажиллагаатай байгууллагуудад 100 гаруй оюутан, суралцагчдыг суралцуулах болон цалинтай дадлага хөтөлбөрт хамруулсан байна.
- 2021 онд Европын холбооны санхүүжилттэй “Эрчим хүчний анхан шатны аудит”-ын төсөлд хамрагдсан.
- 2022 онд байгууллагын магадлан итгэмжлэлд 3 дахь удаагаа амжилттай хамрагдсан.
- 2023 онд БШУЯ-ны Чанарын үнэлгээний шалгалтад амжилттай хамрагдсан.
- 2023 онд Ази-Номхон далайн их, дээд сургуулиудын мобилити (UMAP) холбооны Монгол Улс дахь гишүүн сургуулиар элсэн орсон.
- 2023 онд “Эрдэм шинжилгээ, судалгаа инновацын төв”-ийн дэргэд БНСУ-ын КОМВИН ХХК-тай хамтран “Компьютер засварын төв” байгуулах САНАМЖ БИЧИГ байгуулав.
- 2024 онд Хангай олон улсын сургууль болж БНСУ-ын Ганнам их сургууль, ЖЕЙ их сургууль, Мионжи их сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулав.
- 2024 онд БНСУ-ын ЭМЭС Кория, Жиник Тэк олон улсын байгууллагуудтай хамтран хиймэл оюун ухааны лабораторийг байгуулав.
- 2024-2025 оны хичээлийн жилээс эхлэн Хиймэл оюун ухааны 2+2 олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.

ТЭНХИМИЙН ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн удирдлага, мэдээлэл технологийн тэнхим

Тус тэнхим нь нийт 3, доктор, 4 докторант, 14 магистр багшийн бүрэлдэхүүнтэй ба үүний дотор шинжлэх ухааны доктор 1, профессор багш 3, дэд профессор багш 1, зөвлөх багш 2, ахлах багш 6, арга зүйч багш 4, заах аргач 8 багш ажиллаж байна.

Тэнхимийн зорилго

Мэдээлэл технологийн эрин үед мэргэшсэн, мэдлэгтэй, найдвартай, эрдэм шинжилгээ, инновацын чадавх бүхий боловсон хүчнийг бэлтгэх

Тэнхимийн зорилт

- Олон улсын стандартад нийцсэн чанартай сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Оюутан, суралцагч, багш, ажил олгогч, төгсөгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх
- Оюутан төвт сургалт явуулах
- Чанартай боловсон хүчнийг бэлтгэх

Хэрэгжүүлж буй хөтөлбөр

- Програм хангамж
- График дизайн
- Бизнесийн удирдлага /Бакалавр, магистр/
- Нягтлан бодох бүртгэл /өдөр, орой, эчнээ/
- Аялал жуулчлал
- Орчуулагч-Хятад хэл

Тэнхимийн эрдэм шинжилгээ, судалгаа чиглэл

- Веб дизайн
- Нягтлан бодох бүртгэл
- График дизайн
- Аялал жуулчлал
- Бизнесийн удирдлага

Тэнхимийн онцлог, үйл ажиллагаа

Бизнесийн удирдлага, мэдээлэл технологийн тэнхим нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш оюутан, багш, төгсөгч, ажил олгогчдын эрх ашиг, эрэлт хэрэгцээнд тулгуурласан олон төрлийн сургалт, тэмцээн, уралдаан, арга хэмжээг амжилттай зохион байгуулж сонин, сэтгүүл, телевизээр болон эрдэм шинжилгээний эмхэтгэлээр олны хүртээл болгож ирсэн түүхтэй.

- Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Гадаад хэлний сургалтын агуулга, арга зүй” зөвлөгөөн, семинар
- Мөн улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Гадаад хэлний сургалтын идэвхтэй аргууд” семинар
- Багш нарын эрдэм шинжилгээний бага хурал
- Оюутны эрдэм шинжилгээний бага хурал
- Магистрант оюутнуудын эрдэм шинжилгээний бага хурал
- Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Англи хэлний илтгэлийн тэмцээн”
- Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Англи хэлний үсэглэлийн тэмцээн”
- Гадаад хэлний цагаан толгойн баяр
- Мэргэжил сурталчлах өдөрлөг
- Сургуулийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн
- Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Хичээнгүй бичигтэн” улсын уралдаан
- Санхүүчдийн баяр
- Монголын уламжлалт ёс заншлыг сурталчлах өдөрлөг
- Төгсөгч, ажил эрхлэгчдийн уулзалт арга хэмжээ
- Олон улсын оюутан, багш солилцооны хөтөлбөр
- Олон улсын цалинтай дадлагажигч оюутан хөтөлбөр
- Олон улсын 2+2 хөтөлбөр
- Олон улсын судлаач багш, оюутан хөтөлбөр

Тэнхимийн амжилт

- 2015 онд Н.Алтанжаргал багш Отгонтэнгэр их сургуулиас зохион байгуулсан Англи хэл-Боловсрол олон улсын илтгэлийн тэмцээнд амжилттай оролцож 2-р байр
- 2018 онд ELTAM Англи хэлний багш нарын холбооноос зохион байгуулдаг TESOL олон улсын их хуралд Н.Алтанжаргал багш өөрийн илтгэлийг амжилттай хэлэлцүүлсэн.
- Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагаас жил бүр зохион байгуулдаг заах аргын тэмцээнд багш О.Долгормаа 2018 онд амжилттай оролцож тусгай байр
- Үйлдвэр урлалын политехник коллежоос жил бүр зохион байгуулдаг англи хэлний багш нарын улсын уралдаанд Н.Алтанжаргал багш 2016, 2019 онд амжилттай оролцож тусгай байр
- 2019 онд Б.Энхсүрэн багш МУБИС-ийн Магистр, докторын эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож 3-р байр
- 2020 онд Н.Алтанжаргал багш Үйлдвэр урлалын политехник коллежоос зохион байгуулдаг Англи хэлний багш нарын олимпиад амжилттай оролцож Тусгай байр
- 2020 онд Б.Бат-Амгалан багш Шинжлэх ухаан технологийн их сургуулиас зохион байгуулагдсан эрдэм шинжилгээнд амжилттай оролцож 2-р байр
- 2020 онд Англи хэлний багш Н.Алтанжаргал олон улсын TESOL семинарт улсаа төлөөлөн оролцсон.
- 2019-2021 оны хооронд Европын холбооны санхүүжилттэй “Их, дээд сургуулиудын судалгаа шинжилгээний чадавхыг сайжруулах нь” төсөлд нийт багш нар амжилттай хамрагдсан.

Тэнхимийн багш нар

№	Овог	Нэр	Багшийн төрөл	Боловсролын түвшин	Мэргэжлийн зэрэг
1	Санжбэгз	Төмөр-Очир	Профессор багш	Доктор, ScD	Зөвлөх багш
2	Цэдэндаш	Цэрэнхүү	Профессор багш	Доктор	
3	Төвжаргал	Сосорбарам	Профессор багш	Доктор	Зөвлөх багш
4	Нэмэхбаяр	Алтанжаргал	Дэд профессор багш	Докторант	Арга зүйч
5	Бат-Очир	Нямбаяр	Ахлах багш	Магистр	
6	Батмөнх	Бат-Амгалан	Ахлах багш	Магистр	Арга зүйч
7	Нармандах	Бямбацэдэн	Ахлах багш	Магистр	
8	Орхонтуул	Долгормаа	Ахлах багш	Магистр	Арга зүйч
9	Болд	Энхсүрэн	Ахлах багш	Докторант	Арга зүйч
10	Shinichi	Kubota	Ахлах багш	Магистр	
11	Пүрэвжав	Даваасүрэн	Багш	Магистр	
12	Сарантуяа	Ууганцэцэг	Багш	Магистр	
13	Алтансүх	Жавхланбаяр	Багш	Магистр	
14	Сүсрэндэрэм	Мөнхмаа	Багш	Магистр	
15	Гэрэл	Дариймаа	Багш	Докторант	
16	Лхагвасүрэн	Дуламсүх	Багш	Магистр	
17	Цэсмаа	Лхагватуяа	Дадлагажигч багш	Докторант	
18	Xin	Shen	Дадлагажигч багш	Магистр	
19	Rei-Xuan	Wang	Дадлагажигч багш	Магистр	
20	Шижирбаатар	Мөнхбаатар	Дадлагажигч багш	Магистр	
21	Сүхбаатар	Анужин	Дадлагажигч багш	Магистр	

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТӨЛБӨР

Нягтлан бодох бүртгэлийн бакалаврын хөтөлбөр нь хүнлэг, ёс зүйтэй, хувь хүний ур, чадварыг хөгжүүлсэн, нийгмийн эрэлт, хэрэгцээг хангасан мэргэжлийн ур чадвартай, төрийн болон хувийн хэвшилд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг гүйцэтгэх, зохион байгуулах, үр дүнг тайлагнах, асуудлыг шүүн тунгаах, аливаа асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй хандах салбартаа ёс зүйтэй, хариуцлагатай амжилттай ажиллаж, ахиж дэвшихийн зэрэгцээ аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах, шинийг санаачлах эрмэлзэлтэй, уян хатан бүтээлч сэтгэлгээтэй, мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх дадал, хандлага төлөвшүүлнэ.

ЭЗЭМШИХ МЭДЛЭГ:

- 1.Нягтлан бодогчийн ажлын байранд хамаарах, ажлын даалгаврыг гүйцэтгэх болон шийдвэр гаргахдаа шинжлэх ухааны мэдлэг, техник ур чадварын хүрээний онол зарчмуудыг бие даан гүйцэтгэх
- 2.Байгууллагын НББ-ийн зохион байгуулалтын нөхцөл байдал, мэдээллийн системийг тохируулж өөрчлөх, байгууллагын доторх нөөцийг үр ашигтай ашиглах, хэрэгцээг урьдчилан тооцоолох
- 3.Мэдээлэл харилцааны дэвшилтэт технологи, програм, техник хэрэгслийг ашиглан мэдлэг бүтээх хэрэглэх, цахим орчны мэдээллийг үр дүнтэй ашиглах, түгээх, хуваалцах, хэрэгцээндээ нийцүүлэх
- 4.Инновац технологийн хөгжлийн өргөн хүрээнд ач холбогдлыг таньж мэдэх насан туршдаа хэрэглэх
- 5.Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээлэл дээр шинжилгээ хийж удирдлагын шийдвэр гаргалтад холбогдох мэдээллийг задлан шинжлэх, дүгнэлт гаргах
- 6.Зардлын хөтлөгч, өртгийн шинж чанар дээр шинжилгээ хийх тоон шинжилгээний арга техникийг хэрэглэх, дүгнэлт гаргах, харьцуулах

ЭЗЭМШИХ УР ЧАДВАР:

1. Байгууллагын өнөөгийн болон ирээдүйн санхүүгийн байдлыг судлах, харьцуулах, ашигт ажиллагаа болон үр ашигт байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явцыг сайжруулахын тулд тохирох арга хэрэгсэл, технологийг ашиглах чадамжтай байх
2. Засаглалыг тодорхойлж, байгууллагын үр дүнтэй удирдлага хяналтад гүйцэтгэх удирдлагын үүргийг ялган таних, НББ-ийн дотоод хяналт үүрэг даалгаврыг үнэлэх, эрсдэлийг тодорхойлоход НБ-ын үүргийг ухамсарлах, дүгнэлт гаргах
3. Төлөвлөх, шийдвэр гаргах, гүйцэтгэлийг үнэлэх хянах зорилгоор бизнесийн янз бүрийн нөхцөлд НББ-ийн холбогдох арга техникийг ашиглах бизнесийн янз бүрийн нөхцөлд стратегийн менежментийн НББ-ийн арга техникийг сонгох, мэргэжлийн дүгнэлт хийх, Байгууллагын гүйцэтгэл түүний стратегийн хөгжлийн үнэлгээг төлөвлөх, боловсруулах
- 4.Хөрөнгө, орлого болон зах зээлийн үнэлгээнд суурилсан аргуудыг тайлбарлахдаа хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт, бизнес, төлөвлөлт, урт хугацааны санхүүгийн удирдлагын арга техникүүдийг ашиглах чадвар

КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Карьер хөгжлийн клубийн зорилго нь: Оюутан суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, ажлын байрны шаардлага, ажлын ярилцлагад бэлдэх заалтын тухай, хөдөлмөрийн тухай хуулийн тусгай заалт, тэтгэлэг хөтөлбөрт хэрхэн хамрагдах, оюутан ажил хөдөлмөр эрхлэхэд анхаарах асуудал, ажиллах байгууллагаа зөв сонгох нь, ярилцлагын шалгалтад бэлдэх загвар, ажлын байран дээр тасралтгүй хөгжих, үнэ цэнтэй ажиллах хүчин болох ур чадвар, мэдлэг эзэмшүүлнэ.

МЭРГЭЖЛИЙН ДАВУУ ТАЛ

Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр төгсөгчид нь бүх шатны байгууллагад нягтлан бодогчийн ажлын байрны шаардлагад нийцсэн ажлын даалгаврыг гүйцэтгэх, шинжлэх ухааны мэдлэг, техник ур чадвар, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийг хэрэглэх, байгууллагын доторх нөөцийг үр ашигтай ашиглах, хэрэгцээг урьдчилан тооцоолох, санхүүгийн тайланг боловсруулах, үр дүнг нь удирдлагын шийдвэр гаргалтад ашиглах мэргэжилтэн болж төгсөнө.

АЖЛЫН БАЙРНЫ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ

Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр төгссөн мэргэжилтнүүд дараах ажлын байранд ажиллах бүрэн боломжтой. Үүнд:

- Аудитор
- Нягтлан бодогч
- Санхүүгийн шинжээч
- Эдийн засагч
- Дотоод аудитор
- Татварын зөвлөх
- Санхүүгийн менежер
- Санхүү эрхэлсэн захирал
- Эрсдэлийн шинжээч
- Төсвийн мэргэжилтэн

ЭЗЭМШИХ ПРОГРАМ

Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд дараах програмуудыг судална.

- Эрхэт санхүүгийн програм
- Смарт баланс лайт санхүүгийн програм
- SPSS судалгааны програм
- Stata статистикийн програм

Эдгээр програмуудыг эзэмшсэнээр байгууллагын санхүүгийн тоон мэдээллийг бүртгэх, боловсруулах, санхүүгийн тайланг гаргах, тоон мэдээллийг судалгааны програм дээд боловсруулж үр дүнг нь удирдлагын шийдвэр гаргалтад ашиглах, санхүүгийн нөөцийг үр ашигтай хуваарилж сурна.

БИЗНЕСИЙН УДИРДЛАГА ХӨТӨЛБӨР

ХАНГАЙ ДЭЭД СУРГУУЛЬ НЬ “БИЗНЕСИЙН УДИРДЛАГА” ХӨТӨЛБӨРӨӨР ЗАХ ЗЭЭЛД ӨРСӨЛДӨХ ЧАДВАР БҮХИЙ ОНОЛЫН БОЛОН ПРАКТИК МЭДЛЭГТЭЙ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙГ ЭЗЭМШСЭН, БИЕ ДААСАН БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭТЭЙ, ХАРИЛЦААНЫ ӨНДӨР УР ЧАДВАРТАЙ, ГАДААД ХЭЛНИЙ ЗОХИХ МЭДЛЭГТЭЙ, БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХЭД ОРШИНО.

“БИЗНЕСИЙН УДИРДЛАГА” ХӨТӨЛБӨРӨӨР ОЛГОХ МЭДЛЭГ:

- Дээд боловсролтой мэргэжилтний зайлшгүй мэдвэл зохих хүмүүнлэг нийгмийн ухаан, математик статистик, мэдээллийн систем суурь мэдлэг эзэмших
- Бизнесийн удирдлагын суурь мэдлэг эзэмших
- Бизнесийн баримт бичгийг боловсруулах, бизнесийн харилцаанд оролцох, мэргэжлийн ёс зүйг сахих
- Мэргэжлийн англи хэлний мэдлэг, хэрэглээ
- Тоон болон статистик шинжилгээний аргуудыг эзэмших
- Эдийн засгийн суурь мэдлэг, микро, макро эдийн засгийн онол, нягтлан бодох бүртгэл, санхүү, маркетинг, менежмент, мэдээллийн технологи зэрэг мэргэжлийн суурь мэдлэг
- Мэргэжлийн хүрээнд судалгаа, шинжилгээний ажлыг хийх, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах
- Бие хүний төлөвшлийн болон харилцааны ур чадвар, бүтээлч сэтгэлгээ, илтгэх, мэдээллийн технологи ашиглах, өөрийгөө хөгжүүлэх, манлайлах

“БИЗНЕСИЙН УДИРДЛАГА” ХӨТӨЛБӨРӨӨР ЭЗЭМШИХ ЧАДВАР, ДАДАЛ:

- Бизнесийн удирдлагын шийдвэр гаргах, байгууллагын нөхцөл байдлын судалгаа хийх, маркетингийн төлөвлөгөөнд тусгах стратеги болон тактикийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, багаар ажиллах
- Мэргэжлийн онцлогийг ялган мэдэж, үйл ажиллагааны оновчтой шийдвэр гаргах, байгууллагын нөхцөл байдалд үндэслэн үйлчилгээний зөв стратегийг маркетингийн төлөвлөгөөнд тусгах
- Зах зээлийн нөхцөлийг үнэлж, тулгарч буй асуудлуудыг тодорхойлох болон шийдвэрлэх боломжит хувилбаруудыг боловсруулах, үнэлгээний хэмжүүрүүдийг тодорхойлох, оновчтой төлөвлөх, зохион байгуулах
- Байгууллагад сургалт зохион байгуулах, сургалтын үр дүнг үнэлэх, ажиллагсдын карьер төлөвлөлт хийх
- Хэрэглэгчийг таньж судлах, зан төлөвийг мөн чанарыг тогтоох, амьдралын хэв маяг болон сэтгэл зүйн хүчин зүйлийг тодорхойлох, худалдан авах шийдвэр гаргалтанд үзүүлэх нөлөө, үр дүнг тайлбарлах
- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, санхүүгийн тайланг бэлтгэх, гүйцэтгэлийг хэмжих арга зүй тодорхойлох
- Аудит ба баталгаажуулалт, удирдлагын нягтлан бодох бүртгэл ба хяналт хийх
- Мөнгө, санхүү, эдийн засгийн онол дээр тулгуурлан удирдлагын оновчтой шийдвэр гаргах
- Бизнесийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах, хянах, үр дүнг тайлагнах
- Бизнесийн удирдлага, зохион байгуулалт, менежмент ба стратегийн шийдвэр гаргах
- Байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөө, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах
- Бизнесийн ба арилжааны хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын эрх зүйн баримт бичгийг бүрдүүлж, боловсруулах, багаар ажиллах, ёс зүйтэй, өөрийгөө хөгжүүлэх

Тус мэргэжлээр суралцан төгсөөд нягтлан бодох бүртгэл, санхүү, банк, даатгал, бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрт үргэлжлүүлэн магистрантурт суралцах боломжтой.

ПРОГРАМ ХАНГАМЖ ХӨТӨЛБӨР

Та хаана ажиллах вэ?:

Програм хангамж хөгжүүлдэг компаниудад програмист, сургууль болон байгууллагуудад мэдээлэл технологийн инженер, сүлжээний инженер, мэдээлэл технологийн ажилтан, мэдээлэлзүйн багш хийх боломжтой.

Мэргэжлийн давуу тал

Компьютерийн ухааны мэдлэгтэй, мэргэжлийн түвшиний програм болон програмчлалыг хэлийг мэдлэг, ур чадварын түвшинд эзэмшсэн Програм хангамжийн мэргэжлийн давуу тал нь аль ч салбарын бүх байгууллагад програм хангамжийн төслийн менежер, програм хангамжийн шинжээ, вэб мастер, мэдээлэл технологийн ажилтнаар, бүх шатны сургуулиудад багшаар ажилладагаараа давуу юм.

Эзэмших мэдлэг

Компьютерийн техникийн үндэс, үйлдлийн систем, сүлжээний болон системийн програмчлал, алгоритм, өгөгдлийн сан боловсруулах, системийн шинжилгээ, зохиомж, өгөгдийн бүтэц, өгөгдлийн сан, програмчлалын технологий, компьютерийн загварчлал, програмчлалын хэлний парадигми, програм хангамжийн төслийн менежмент, програм хангамжийн системийн шинжилгээ, зохиомж, тестчлэл хийх мэдлэгийг эзэмшинэ.

Эзэмших ур чадвар

Компьютерийн үйлдлийн систем суулгах, сүлжээ үүсгэх, ажлын програмын орчин бүрдүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын танилцуулга веб хуудас хөгжүүлэх болон динамик веб хуудас зохиох, хөгжүүлэх, тест хийх, интернетийн орчинд байршуулах, олон нийтийн сүлжээнд холбох, бүртгэлийн болон удирдлагын мэдээллийн системд зохиох, хөгжүүлэх, тест хийх, тайлан гаргах, аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн системд дүгнэлт хийх сайжруулах загвар гаргах, гар утасны програм зохиох, хөгжүүлэх ур чадварыг эзэмшинэ.

Эзэмших програм

Хэрэглээний програм хангамж word, excel, powerpoint, зургийн paint програм, програмчлалын хэл C, C++, java, phyton, вэб хийх HTML, CSS, PHP, хэл, Eclipse, Dreamweaver програм, мультимедиа flash програм, өгөгдлийн сан боловсруулах Access, SQL, MySQL програмчлалын хэл болон мэргэжлийн түвшиний visual studio, android studio програмуудыг судлан эзэмшсэн байна.

Онцлог

Мэдээлэл технологийн орчин үеийн чиг хандлага, програм хангамжийн хөгжил, шинээр гарч ирж байгаа програмуудыг судлан практикт ашиглах, түүний судлан, хөгжүүлэх, тестчлэх, програм хангамжийн програмуудыг үр дүнтэйгээр ашигладаг, хэрэглэгчийн шаардлагыг хангасан програм хангамж хөгжүүлэх, нэвтрүүлэх онцлогтой.

Ажлын байрны эрэлт

Програмист болон мэдээлэл технологийн инженер нь эрэлттэй ажлын байрны тэргүүнд орж байгаа бөгөөд аль ч түвшиний салбарт ажиллах боломжтой мэргэжил юм. Үүнд:

- Програм хөгжүүлэгч /програмист/
- Мэдээлэл технологийн инженер
- Сүлжээний инженер
- Мэдээлэл технологийн ажилтан
- Системийн шинжээч
- Систем хөгжүүлэгч зэрэг мэргэжлүүдээр ажиллах бүрэн боломжтой.

ГРАФИК ДИЗАЙН ХӨТӨЛБӨР

Та хаана ажиллах вэ?

Хэвлэлийн үйлдвэрийн бүхий л салбарт, Дотоод гадаадын банк, бизнесийн байгууллага, Гэрэл зургийн студи, Зураг төслийн компанид гэх мэт байгууллагат ажиллах боломжтой.

Мэргэжлийн давуу тал

Үйлдвэр албан байгууллага, хэвлэл мэдээлэл, мэдээлэл сурталчилгааны газарт үйлдвэрлэл, чимэглэлийн график дизайнераар ажиллаж, бүтээгдэхүүний хийц дүр төрхийг бий болгох, сав баглаа боодол, барааны танилцуулга, лого тэмдэгт, реклам сурталчилгааны зурагт хуудас тэдгээрийн уран сайхны зураг төсөл, эх загварыг зохиож, үйлдвэрлэл үйлчилгээ хэрэглээнд нэвтрүүлэх, зохион бүтээлтийн мэргэжилтэн болж бэлтгэгдэнэ.

Эзэмших мэдлэг

Хүмүүнлэг, байгалийн ухааны суурь мэдлэгтэй болох, зураглах ур чадварт суралцах, мэргэжлийн өндөр ур чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй хөгжүүлэх, өрсөлдөх чадвартай байх, Компьютер, график дизайны хэрэглээний тухай мэдлэг, түүний хөгжлийн хурдацыг дагаж өөрийгөө хөгжүүлэх мэдрэмжтэй, дүрслэлийн шинжлэх ухаан, урлагийн онол, түүхийн суурь онолуудын харьцангуй бүрэн цогц мэдлэгтэй, дизайны өндөр мэдрэмж, сэтгэлгээтэй, салбар шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлага, судалгааны арга барил мэдлэгийг эзэмшүүлнэ.

Эзэмших ур чадвар

- Багийн зохион байгуулалтаар ажиллах, түүнийг удирдах чадвар эзэмших
- Шинийг санаачлах эрмэлзэлтэй, уламжлалыг дээдлэн, уян хатан бүтээлч сэтгэлгээтэй байх чадвар, хувь хүний мэдлэг, ур чадвар, төлөвшилийг үнэлж, ухамсарладаг, бие даан суралцах ба цагийн болон нөөцийн менежментийг хэрэгжүүлдэг байх чадвар,
- Мэргэжлийн ёс зүйтэй, хариуцлагатай, чадвартай, эдийн засгийн хувьд тооцоотой байх чадвар
- Өөрийгөө хөгжүүлэн мэргэжлээ дээшлүүлэх чадвар
- Үйлдвэрлэл, бизнесийн хүрээнд амжилттай ажиллах чадвар
- Санал бодлоо илэрхийлэх, баталгаажуулах, цахим хэрэгсэл, график, схем, мультимедиа дүрслэл ашиглах чадвар
- График дизайнер хүний мэргэжлийн болон бизнесийн ёс зүй чадвар
- Компьютер дизайны мэргэжлээр суралцагсад компьютерийн хэрэглээний програмын тусламжтайгаар үсгийн урлал түүнийг гүйцэтгэх арга ажиллагаа, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний сав баглаа боодол, лого, арилжаа сурталчилгааны зурагт хуудас, номын зураг чимэглэл, бэлэг дурсгалын зүйлс, загвар, зураг-төслийн эхийг зохиож хэрэглээнд нэвтрүүлэх мэдлэг чадвар эзэмшинэ.

Эзэмших програм

Компьютер график дизайны мэргэжлээр сурсан оюутангууд: Дараах програмуудыг судалж мэдсэн байна. Үүнд:

- Adobe Photoshop
- Adobe Indesign
- Adobe Illustrator
- Adobe Premiere
- Adobe After Effect
- Adobe Flash
- 3D аномнишн
- Мультимедиа
- Corel Draw эдгээр програмуудыг эзэмшиснээр та график дизайны хавтгайн буюу растер, уран дүрслэл буюу вектор, биет буюу 3D орчин дахь бүх төрлийн график дизайныг хийж гүйцэтгэж ажиллаж сурахаас гадна хөдөлгөөнт анимэйшн, хэвлэлийн эх бэлтгэл, видео эвлүүлэг, график дүрслэл гэх мэт компьютер графикийн туслах ажлуудыг бүрэн хийж сурах юм.

Онцлог

Орчин үед зайлшгүй хэрэгтэй мэргэжлүүдийн нэг болоод байгаа график дизайны мэргэжил нь байгууллагын өнгө төрх, хэв маяг, маркетинг, борлуулалттай шууд холбоотой. График дизайн

хөтөлбөрөөр суралцагсад нь уран төсөөлөл, бүтээлч байдал, ур чадвар, бааар ажиллах чадвар, үр ашигтайгаар үйлчлүүлэгч, хэрэглэгчтэйгээ харилцахад тусалдаг, ёс зүйтэй, харилцааны өндөр ур чадвартай, зах зээлд эрэлт хэрэгцээ өндөртэй мэргэжилтэн юм.

Ажлын байрны эрэлт

График дизайн мэргэжлийн сонгосноос ажлын байран дээрх эрэлт. Үүнд:

- Дотоод гадаадын банк, бизнесийн байгууллагуудад дизайнер
- Студи продакшны дизайнер
- Хэвлэлийн үйлдвэрийн бүхий л салбарт дизайнер
- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, телевизийн дизайнер
- Маркетингийн салбарт дизайнер
- Сурталчилгааны агентлагуудад дизайнер
- Зураг төслийн компаниудад дизайнер
- Вэб дизайнер
- Гэрэл зургийн студын дизайнер

ХЯТАД ХЭЛНИЙ ОРЧУУЛАГЧ

Хятад хэлний гарал үүсэл хөгжил, авиа зүй, Хятад хэлний авианы нэгж буюу үе, үеийн бүтэц, түүний онцлог, хятад хэлний хөг аялга, түүний үүрэг, орчин цагийн ханз, түүний бичлэгийн онцлог, зөв бичих дараалал, Хятад хэлийг анхан шатнаас ахисан түвшинд ярих, унших, сонсох, бичих үндсэн дөрвөн ур чадваас гадна эх хэлнээс хятад хэл рүү, хятад хэлнээс эх хэл рүү аман болон бичгийн орчуулга хийх чадварыг эзэмшүүлнэ.

Сургалт явуулж ирсэн түүх, туршлага: “Хангай” дээд сургууль нь 2001 онд Мэдээлэл технологи, аялал жуулчлалын чиглэлээр байгуулагдаж өдгөө 21 дахь жилдээ сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Тус сургууль нь 2006 онд анхны, 2012 онд ахисан түвшинд магадлан итгэмжлэгдсэн, 2013 онд БСШУСЯ-аас аттестатчилагдсан билээ.

2001 оны 09 сарын 01-ний өдрөөс эхлэн Хангай коллеж D220706 индекстэй орчуулагч (хятад хэл), 2014 оноос D023101 индекстэй гадаад хэлний орчуулга (хятад) мэргэжлээр элсэлтээ авч, хамтран ажиллах гэрээний үндсэн дээр БНХАУ-ын Тайваны Минг Чуан их сургуультай хамтран жил болгон хятад багш ирж хичээл ордог. 2011 онд хятад хэлний сайн дурын багш Сүн Шүэ Жуан, 2012 онд Ван Цай Хуа, 2013 онд На Рина, 2015 онд ӨМӨЗО-ны багш Гэгэнтана, 2016 онд Янг Хонг, 2017 онд Ву Шуань, Ху Шу Вен, 2017 онд мөн Цай Линг Юн, 2018 онд Сэнг Гэ, 2018-2019 оны хичээлийн жилд Ху Шаохуа багш ирж ажилласан бөгөөд 2020 оноос эхлэн цар тахлын улмаас шалтгаалан сургалтыг цахим хэлбэрээр zoom ашиглан төлөвлөгөөний дагуу хичээл орж байна.

Хятад хэлний орчуулагч мэргэжлийн хичээлийг онолын болон дадлагын хичээлтэй хослуулан танилцах буюу төгсөлтийн өмнөх дадлага гэсэн 2 төрлийн дадлага ажлыг гүйцэтгүүлэн суралцагчдыг төгсгөж байна. Хангай дээд сургууль нь 2001 онд үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн гадаадын их дээд сургууль, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, туршлага солилцон, өөрийн сургуулийн оюутан, суралцагчдыг гадаадын их, дээд сургуулиуд болон байгууллагуудад дадлагажуулах мөн зарим байгууллагуудад ажиллуулах, бакалавр, магистр, докторын сургалтуудад тэтгэлэгтэйгээр хамруулах, оюутан солилцоо болон дипломын сургалтад хамруулах зэргээр хамтран ажиллаж ирсэн туршлагатай билээ. Хангай дээд сургууль нь өдгөө 16 гаруй орны 500 гаруй их, дээд сургууль, байгууллагуудтай оюутан солилцоо, дадлага ажил гүйцэтгэх, хамтран ажиллаж байна. Гадаад болон дотоодын мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай магистр, докторын зэрэгтэй ахлах болон зөвлөх багш нарын бүрэлдэхүүнтэй сургалтын үйл ажиллагаагаа өнөөг хүртэл явуулж ирсэн түүхтэй.

Хөтөлбөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлага: Дэлхий даяарчлагдаж байгаа энэ үед мэдээлэл маш хурдтай солилцох нь зайлшгүй шаардлага болж байна. Харин хятад хэл сурсанаар энэ том өөрчлөлтийг улам эрчимтэй, өргөн хүрээтэй болгоно. Хятад хэл сурснаараа, хувь хүний хувьд өрсөлдөх чадвар нь өсч, давуу тал болж чаддаг учраас хэрэгцээ их болсон. Мөн тухайн улсад суралцахыг дэмжиж БНХАУ-ын засгийн газрын тэтгэлэг, бусад тэтгэлэгүүд их байдаг учраас гадаадад сурах хүсэлтэй боловч санхүүгийн байдлаас

шалтгаалаад залуус тэрхүү суралцах боломжоо олж авч чадахгүй нь нийтлэг байдаг залуусын хувьд сургалтын тэтгэлэг нь маш их сурах, хөгжих боломжийг бүрдүүлж байна. Мөн дэлхий дахинд маш эрчимтэй хөгжиж буй аялал жуулчлалын салбарт гадаад хэлний мэдлэгтэй хүмүүсийн эрэлт өсөж, мөн ажлын байран дээр маш өндөр үнэлэгддэг мэргэжлийн нэг бол орчуулагч юм.

ХИЙМЭЛ ОЮУН УХААН

Хөтөлбөрийн зорилго: Хиймэл оюун ухааны хөтөлбөрийн зорилго нь программ хангамж, техник хангамжийн системийг зохион бүтээхэд тулгарч буй асуудлуудад хиймэл оюуны арга аргачлал, алгоритм, загварыг боловсруулж хэрэгжүүлэх, онолын мэдлэг боловсролтой, мэргэжлийн, төрийн болон судалгааны байгууллагуудад бүтээлчээр ажиллах мэргэжилтэн бэлтгэх явдал юм. Мөн түүнчлэн хиймэл оюун ухаанаар бүтэх програм, бүтээлүүдийг бий болгох, дрон, дроны загварчлал боловсруулах зэрэг хиймэл оюун ухаанаар бүтэх бүтээлүүдийг боловсруулах нь энэхүү хөтөлбөрийн гол зорилго юм.

Хиймэл оюун ухааны хөтөлбөр нь БНСУ-ын JEl, MYONGJI university, Kangnam university зэрэг их сургуулиудтай 2+2 хөтөлбөрөөр суралцах боломжтой. Энэхүү 2+2 хөтөлбөрөөр суралцсанаар Хиймэл оюун ухаан мэргэжлээр өндөр цалинтай ажиллана, сургалтыг БНСУ-ын тэргүүлэх чиглэлийн эрдэмтдийн баг удирдан явуулна, хиймэл оюун ухааны сургалт, судалгааны төвд ажиллах, БНСУ-ын компаниудад мэргэжлээрээ үндсэн ажилтнаар ажиллах, олон улсын ISO стандартын шаардлага хангасан гэрчилгээтэй төгсөх боломжтой.

Ажлын байр:

Хиймэл оюуны шинжээч

Ухаалаг бизнесийн шинжээч

Хиймэл оюун хөгжүүлэгч

Гүн сургалт хөгжүүлэгч

Гүн сургалтын инженер

Өгөгдлийн шинжээч

Хиймэл оюун

Хиймэл оюуны инженер

Машин сургалтын инженер

Компьютерийн харааны инженер

ХО/Эх хэлний боловсруулалтын судлаач

Хиймэл оюун ухааны програм хангамжийн хөгжүүлэгч

ТЭНХИМИЙН ТАНИЛЦУУЛГА

Сурган, сэтгэл судлалын тэнхим

2017 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд тус тэнхим нь нийт 14 доктор, 3 докторант, 6 магистр багшийн бүрэлдэхүүнтэй ба үүний дотор шинжлэх ухааны доктор 2, профессор багш 15, дэд профессор 1, зөвлөх багш 5, тэргүүлэх багш 4, ахлах багш 2 ажиллаж байна.

Тэнхимийн зорилго

Сурган сэтгэл судлал, боловсрол судлалын чиглэлээр сургалт, судалгааны ажил эрхлэн орчин үеийн шаардлагад нийцсэн зөв хандлагатай, бүтээлч, ёс зүйтэй багш бэлтгэх.

Тэнхимийн зорилт

- Үндэсний хэмжээний хөгжилд хувь нэмэр оруулах шаардлагад нийцсэн эерэг хандлагатай боловсон хүчнийг бий болгох
- Олон улсын стандартад нийцсэн чанартай сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Оюутан, суралцагч, багш, ажил олгогч, төгсөгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх
- Оюутан төвт сургалт явуулах
- Хүүхдэд ээлтэй орчин үеийн зөв хандлага, төлөвшилтэй багш бэлтгэх
- Үндэсний хэмжээнд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц мэргэжилтэн багш бэлтгэн гаргах

Хэрэгжүүлж буй хөтөлбөр:

- Багш, бага боловсрол
- Багш, сургуулийн өмнөх боловсрол
- Багш, мэдээлэл зүй
- Багш, гадаад хэлний боловсрол
- Боловсрол судлалын магистр

Тэнхимийн эрдэм шинжилгээ, судалгаа чиглэл

- Хэл шинжлэл
- Боловсрол судлал
- Сурган хүмүүжүүлэх зүй
- Мэдээллийн технологи

Тэнхимийн онцлог, үйл ажиллагаа

Сурган сэтгэл судлалын тэнхим нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш оюутан, багш, төгсөгч, ажил олгогчдын эрх ашиг, эрэлт хэрэгцээнд тулгуурласан олон төрлийн сургалт, тэмцээн, уралдаан, арга хэмжээг амжилттай зохион байгуулж сонин, сэтгүүл, телевизээр болон эрдэм шинжилгээний эмхэтгэлээр олны хүртээл болгож ирсэн түүхтэй.

- Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Гадаад хэлний сургалтын агуулга, арга зүй” зөвлөгөөн, семинар
- Мөн улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Гадаад хэлний сургалтын идэвхтэй аргууд” семинар
- Багш нарын эрдэм шинжилгээний бага хурал
- Оюутны эрдэм шинжилгээний бага хурал
- Магистрант оюутнуудын эрдэм шинжилгээний бага хурал
- Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Англи хэлний илтгэлийн тэмцээн”
- Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Англи хэлний үсэглэлийн тэмцээн”
- Гадаад хэлний цагаан толгойн баяр
- Мэргэжил сурталчлах өдөрлөг
- Монгол хэлний багш, тухайн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дэнд зохион байгуулагддаг “Эх хэл бидний бахархал” уралдаан
- Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Хичээнгүй бичигтэн” улсын уралдаан

Тэнхимийн амжилт

- Үйлдвэр урлалын политехник коллежоос жил бүр зохион байгуулдаг цахим хичээлийн уралдаанд Г.Цэрэндолгор багш 2016, 2018 онд амжилттай оролцож тусгай байр
- “Их, дээд сургуулийн сургах зүйн шинэчлэлийн зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд Д.Дулаанцэцэг багш амжилттай оролцсон.

- Д.Дулаанцэцэг багш “Монголын дээд боловсролын шинэчлэлийн тулгамдсан асуудлууд, хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд амжилттай оролцож тусгай байр.
- Гадаад хэлний сургалтын агуулга, арга зүй зөвлөгөөн семинарыг улс, олон улсын хэмжээнд 12 жил дараалан амжилттай зохион байгуулж давхардсан тоогоор 1000 гаруй багш, судлаачдыг хамруулсан.

Тэнхимийн багш нар

№	Овог	Нэр	Багшийн төрөл	Боловсролын түвшин	Мэргэжлийн зэрэг
1	Төмөр-Очир	Цэнд-Аюуш	Профессор багш	Доктор	Тэргүүлэх
2	Саменбек	Айнагүл	Профессор багш	Докторант	Тэргүүлэх
3	Дашравдан	Чимэдцэрэн	Профессор багш	Доктор	Зөвлөх
4	Цэгмэд	Цэвээн	Профессор багш	Доктор, ScD	Зөвлөх
5	Энхбаяр	Равдан	Профессор багш	Доктор, ScD	Зөвлөх
6	Мянгаа	Саранцэцэг	Профессор багш	Доктор	Зөвлөх
7	Лхамсүрэн	Сарангэрэл	Профессор багш	Доктор	Зөвлөх
8	Цэрэн	Үрэлмаа	Профессор багш	Доктор	
9	Батчулуун	Мөнгөнхөлөг	Профессор багш	Доктор	
10	Дийзгар	Баттогтох	Профессор багш	Доктор	
11	Цэнджав	Цэрэндорж	Профессор багш	Доктор	
12	Чойжилжав	Дэчинпунцаг	Профессор багш	Доктор	
13	Мужаан	Мөнхжаргал	Профессор багш	Доктор	
14	Батсүх	Бэхтөр	Профессор багш	Доктор	
15	Ёндонжав	Эрдэнэцэцэг	Профессор багш	Магистр	Тэргүүлэх
16	Бавуу	Энхтуяа	Дэд профессор багш	Доктор	
17	Нямаа	Отгонбаяр	Ахлах багш	Докторант	
18	Ням-Осор	Долзодмаа	Ахлах багш	Магистр	Тэргүүлэх
19	Лувсандорж	Билгүүнтөгс	Багш	Докторант	
20	Сүхээ	Мөнхцэцэг	Багш	Магистр	
21	Баярсайхан	Сарантуяа	Багш	Магистр	
22	Сумъяасүрэн	Цэрэнтогтох	Багш	Магистр	
23	Нямаа	Энхтунгалаг	Багш	Магистр	

БАГШ, ГАДААД ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн нэр, индекс:

Багш, гадаад хэлний боловсрол, D011409

Хөтөлбөрийн зорилго, тодорхойлолт:

“Англи хэлний багш” бэлтгэх тус хөтөлбөрийн зорилго нь суралцагчдад англи хэлний болон багшлах онол, арга зүйн мэдлэг, ур чадварыг эзэмших таатай нөхцөлийг бүрдүүлж, англи хэлийг албан болон албан бус хэрэгцээнд ашиглах, орчуулах, түүнийг үр дүнтэй түгээн дэлгэрүүлэхэд оршино. Тус хөтөлбөрөөр суралцагч нь тухайн мэргэжлийн онцлогийг харгалзан сургалтын ажлыг оновчтой төлөвлөх, зохион байгуулах, бие хүний төлөвшил, нийгэмших үйл явцыг дэмжих сургалтын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг бүтээлчээр сонгож хэрэглэх, суралцагчдад боловсролын стандартын шаардлагад нийцсэн мэдлэг,

чадвар эзэмшүүлэх, холбогдох хууль тогтоомжид тусгагдсан суралцагчдын эрхийг хангах, хамгаалах, авьяас билгийг хөгжүүлэх, эцэг эх, төр, олон нийттэй хамтран ажиллах чадвартай багш-бие хүнийг бэлтгэхэд оршино.

Англи хэлний багш мэргэжлийн шинэчлэн боловсруулсан хөтөлбөрөөр суралцагч нь дээд боловсролын ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн 122багц цагийн хичээлийг холбогдох дүрэм журмын дагуу амжилттай судалж, 2.0-оос дээш голч дүнтэй, англи хэлийг анхан шатнаас ахисан түвшинд заах арга, ур чадвар эзэмшсэн, өөрийн үйл ажиллагаандаа англи хэл дээрх эх зохиол, ном сурвалжуудыг бүтээлчээр ашиглах, Англи-Монгол хэлний аман болон бичгийн орчуулга хийх чадвартай мэргэжилтнийг бэлтгэнэ.

Сургалтын хөтөлбөрийн ерөнхий суурь хэсэгт нийт заавал судлах 12 хичээл

/32 багц цаг/, сонгон судлах нийт 16 хичээл буюу хүмүүнлэг, нийгэм, байгалийн ухааны 3 багц хичээл /6 багц цаг сонгон судлах/, мэргэжлийн суурь хэсэгт заавал судлах нийт 10 хичээл /25 багц цаг/, сонгон судлах 4 хичээл /4 багц цаг сонгон судлах/, мэргэжлийн хэсэгт заавал судлах нийт 14 хичээл /41 багц цаг/, сонгон судлах 5 хичээл /4 багц цаг сонгон судлах/, мэргэжлийн чиглэлээр 2 курсийн ажил бичих, 8 багц цагийн дадлага ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Сургалтын агуулгын хувьд англи хэлний багш хөтөлбөрийн мэргэжлийн болон мэргэжлийн суурь хичээлүүд болох Мэргэжлийн дидактик 1, 2, Сургалтын онол арга зүй, Сурган хүмүүжүүлэх зүй, Сэтгэл судлал, Хэлний онол, Хэл шинжлэлийн удиртгал, Англи-Америк орон судлал, Англи-Монгол зэрэгцүүлсэн хэлзүй, Хөтөлбөр судлал, Англи хэлний яриа бичгийн дадлага, Англи хэлний орчуулга 1-3, Албан бичгийн орчуулга, Аман орчуулга зэрэг хичээлүүдийг заавал болон сонгон судлах байдлаар агуулгын давхардалгүй оруулсан.


Энэхүү мэргэжлээр төгсөгч нь англи хэлний онол, ярих, орчуулах хэрэглээний цогц мэдлэг, харьцуулсан хэл шинжлэл, заах арга зүй, сурган хүмүүжүүлэх зүй, хэл-соёл, хэлнийгэм, хэл-сэтгэхүй, хэл угсаа гарал, хэл-ёс заншил, хэл логик гэх мэт хосолсон харьцаан дээр тулгуурласан онол арга зүйн үндсэн мэдлэг эзэмшсэн байна. Англи хэлээр эх зохиох, хоёр хэл рүү орчуулах, ярианы болон бичгийн хэлийг ашиглах, найруулах ёсыг адил тэгш эзэмшсэн байна. Англи хэлний авиа зүй, үгзүй, өгүүлбэрзүй, үгийн сан, хэл найруулгын онцлог, төрөл бус хэлний үзэгдлийг эргэцүүлэн тайлбарлаж, хялбар ойлгуулах чадвар эзэмшсэн байна.

Англи хэлний аливаа баримтад шинжлэх ухааны үндэстэй ажиглалт шинжилгээ хийх, засаж боловсруулах, англи хэлээр өөрөө зохион найруулж бичих, тоочихуй, тайлбарлахуй, хүүрнэхүй, эргэцүүлэхүй, зохион бичих болон сурагчдад энэ чадварыг эзэмшүүлэх арга зүйд суралцсан, англи хэлийг сурталчлах, мэргэжлийн бус хүмүүст англи хэлний хэл зүй, ярих, орчуулах, зөвлөгөө туслалцаа үзүүлэх, багшлах дадал, сурган хүмүүжүүлэх эв дүй, сэтгэл судлалын практик чадварыг эзэмшсэн байна. Сүүлийн үеийн сургалтын арга технологи, сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, мэргэжлийн дидактикийн үндсэн мэдлэгийг эзэмшсэн байна.

Мэргэжлийн давуу тал

- Англи хэлний анхан шатны төвшнөөс ахисан шатны түвшин хүртэл англи хэлийг эзэмших
- Англи хэлний заах арга, ур чадварт суралцах
- Англи хэлний хичээлийн орчин үеийн шинэлэг, сургалтын идэвхтэй аргуудад суралцах
- Багшлах дадлага, заах аргын дадлагад 3 удаа гарах
- Өөрийн мэргэжлийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил бичих, англи хэл дээр судалгааны ажил бичиж олон улсын нэр бүхий сэтгүүлд хэвлүүлэх
- Судалгааны орчин үеийн лабораторид, судалгаа шинжилгээний програм дээр ажиллах
- Англи хэлний олон улсын түвшин тогтоох шалгалт болох IELTS, TOEFL-ийн шалгалтад бэлдэх, шалгалт өгөх арга барилд суралцах


Эзэмших мэдлэг



Эзэмших ур чадвар

Англи хэлний ур чадвар	Заах арга зүйн ур чадвар	Орчуулгын ур чадвар
<ul style="list-style-type: none"> • Англи хэлний ахисан түвшинд чөлөөтэй ярих, сонсох, унших, бичих • Олон улсын түвшин тогтоох шалгалтын арга барил эзэмших • Интернет орчинд ажиллах • Олон улсын зах зээлд чөлөөтэй харилцах 	<ul style="list-style-type: none"> • Англи хэл заах • Багшийн ёс зүй, сахилга батыг баримтлах • Орчин үеийн сургалтын идэвхтэй аргуудыг ашиглах • Суралцагчидтай зөв, боловсон харилцах • Судалгаа, шинжилгээний ажил бичих • Сургалтын програмуудыг ашиглах • Хичээл сургалтын материал боловсруулах, төлөвлөх • Үнэлгээ, сорилын материал боловсруулах • Сургалтын үр өгөөжийг түгээн дэлгэрүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Аман орчуулга хийх • Бичгийн орчуулга хийх • Албан бичгийн найруулга хийх

Эзэмших програм хангамж



Онцлог

- Англи хэлний багш мэргэжлээр суралцан төгссөн оюутан англи хэлний ахисан шатны түвшний мэдлэг, заах арга барил, ур чадвар, орчуулах арга барил, орчуулгын онолд суралцах ба төгсөөд ажлын байранд гарах боломж нээлттэй. Мөн энэхүү мэргэжлээр төгссөн оюутан багш мэргэжлээр ажиллах мөн орчуулагч, хөтөч тайлбарлагч мэргэжлээр хөрвөж ажиллах боломжтой.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа:

- Дөрвөн жил – Ерөнхий боловсрол төгссөн суралцагчид
- Хоёр жил – Хөрвөн суралцах суралцагчид буюу өмнө нь бакалаврын болон түүнээс дээш боловсрол эзэмшин төгссөн суралцагч

Хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн түүхэн туршлага, гаргасан амжилт:

БСШУ-ны сайдын 2001 оны 175 дугаар тушаалаар Багш, мэдээлэл зүй-англи хэлний /D140811/, БСШУ-ны сайдын 2010 оны 06 сарын 29-ний өдрийн 315 дугаар тушаалаар Багш, англи хэлний /D143200/, БШУС-ын 2014 оны 03 сарын 13-ны өдрийн A/78 дугаар тушаалаар Багш, гадаад хэлний боловсрол /D011409/ индекстэйгээр Англи хэлний багш хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Мэргэжлийн хичээлүүдийг гадаадын болон дотоодын доктор, профессор багш нар зохион байгуулж ирсэн түүхтэй бөгөөд мэргэжлийн хичээлүүдийг онолын болон дадлагын хичээлтэй хослуулан Сурган хүмүүжүүлэх, Багшлах дадлага I, II гэсэн 3 төрлийн дадлага ажлыг хийж төгсөх болзлыг хангадаг. Суралцагчид төр, хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын сургуульд дадлага удирдагч багшийн хамт 30-45 хоногийн хугацаанд дадлага хийн, дадлага ажлаа хамгаалдаг.

Хангай дээд сургууль нь үүсгэн байгуулагдсан цагаас эхлэн гадаадын их, дээд сургууль, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, туршлага солилцон, өөрийн сургуулийн оюутан, суралцагчдыг гадаадын их, дээд сургууль, байгууллагуудад дадлагажуулах, ажиллуулах, бакалавр, магистр, докторын сургалтуудад тэтгэлэгтэй хамруулах, оюутан солилцоо болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах зэргээр хамтран ажиллаж ирсэн туршлагатай. Тус сургууль нь одоогийн байдлаар 9 орны 18 их, дээд сургууль, коллежуудтай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг. 2016 онд Монголын хувийн их, дээд сургууль, коллежуудын холбоог байгуулсан бөгөөд уг холбоо нь Японы хувийн их, дээд сургууль, коллежуудын холбоотой хамтран ажилладаг. Уг холбоонд өдгөө 407 их, дээд сургууль, коллежууд хамрагддаг ба эдгээр сургуулиудтай багш, оюутан солилцоо, хамтарсан

хөтөлбөр, цалинтай дадлагажигч оюутан зэрэг хөтөлбөрөөр идэвхтэй хамтран ажиллаж байна.

2014-2015 оны хичээлийн жилээс Америкийн Нэгдсэн Улсын элчин сайдын яамны Фулбрайт Англи хэлний туслах багшийн хөтөлбөрт хүсэлт гарган, тогтмол идэвхтэй хамтран ажиллаж байна. Тус хөтөлбөрийн анхны багшаар АНУ-ын багш Сарах Томлинсон томилогдсон бөгөөд тус багш нь магистрын зэрэгтэй дэлхийн олон улс орнуудад англи хэл зааж байсан арвин туршлагатай мэргэжлийн англи хэлний багш байсан. Сарах Томлинсон ажиллаж байх хугацаандаа Гадаад хэлний тэнхимд хоёр удаагийн заах аргын семинар, Хан-Уул дүүргийн Гадаад хэлний багш нарын дунд Англи хэлний заах аргын семинар, Англи хэлний багш нарын заах аргын олон улсын их хуралд тус тус илтгэл хэлэлцүүлж байсан.

2015-2016 оны хичээлийн жилд Англи хэлний багшаар Самуэл Окинлаби ажилласан. Самуэл Окинлаби багш нь олон жилийн туршлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай багш байсан бөгөөд сургуулийн Халлоувины баяр, Гадаад хэлний цагаан толгойн баяр зэрэг олон арга хэмжээг зохион байгуулахаас гадна, багш нарын дунд Заах арга, ур чадварын семинарыг удирдан явуулж байсан.

2016-2018 оны хичээлийн жилд Япон улсын иргэн Икүо Кобаяаши англи хэлний багшаар ажилласан бөгөөд мэргэжлийн заах арга, ур чадвар сайтай, олон жил англи хэл заасан арвин туршлагатай багш байсан. Кобаяаши багш нь ажиллаж байх хугацаандаа гадаад хэл, заах арга зүйтэй холбоотой арга хэмжээнүүдийг зохион байгуулж, гадаад харилцааны хүрээнд сургуулиа төлөөлөн телевизийн нэвтрүүлэг, ярилцлага, танилцуулгад идэвхтэй оролцож, үр бүтээлтэй ажиллаж байсан.

2018-2019 оны хичээлийн жилд англи хэлний багш Фулбрайт хөтөлбөрийн тэтгэлэгт багш Маргарит Линдрүүт ажилласан. Маргарит Линдрүүт нь Англи, Орос, Турк, Араб хэлний мэдлэгтэй олон улс орнуудад англи хэлийг зааж байсан туршлагатай бөгөөд ажиллаж байх хугацаандаа Гадаад хэлний цагаан толгойн баяр, Англи хэлний илтгэлийн улсын тэмцээн, Гадаад хэлний сургалтын идэвхтэй аргын үндэсний семинар, Сурах арга зүйн семинарыг бусад сургалтын байгууллагын гадаад хэлний багш нарт болон сургуулийн оюутнуудын дунд зохион байгуулсан зэрэг маш олон үр бүтээлтэй ажлуудыг амжилттай, чанартай хийж гүйцэтгэж байсан.

2021-2023 оны хичээлийн жилээс Фулбрайт англи хэлний туслах багш хөтөлбөрийн тэтгэлэгт багш Алисон Грийнфиелд тус сургуульд ажиллаж байна.

2023-2024 оны хичээлийн жилд Филиппин улсын багш Даника Маркуиз англи хэлний багшаар тус тус ажиллаж байна.

Гадаад, дотоодын мэргэжлийн өндөр ур чадвартай, магистр, докторын зэрэгтэй, зохион байгуулах ур чадвар сайтай багш нараар англи хэлийг заан явуулж байсан түүхтэй.

Амжилт:

Сургалт явуулж эхэлснээс хойш нийт 100 гаруй төгсөгчийг төгсгөж, ажлын байранд гаргасан бөгөөд төгсөгчдийн 90 гаруй хувь нь мэргэжлийн дагуу улсын болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургууль, МСҮТ, коллеж, сургалтын төвүүдэд амжилттай ажиллаж байна. Тухайлбал: 2016 оны төгсөгч Б.Дуламцэрэн 34-р дунд сургуульд, 2016 оны төгсөгч Э.Хонгорзул Хангай дээд сургуульд, 2017 оны төгсөгч Б.Уранцэцэг Арвист Хангай бүрэн дунд сургуульд, 2018 оны төгсөгч С.Мөнхсолонго 127 дугаар дунд сургуульд, 2020 оны төгсөгч Д.Солонго “Наран Энх” сургалтын төвд, 2021 оны төгсөгч Д.Хишигзул Хүнсний Политехник коллежид англи хэлний багшаар зэрэг мэргэжлийн дагуу амжилттай ажиллаж байна.

Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага, зах зээлийн эрэлт хэрэгцээ:

Монгол улсад 16 орчим төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд англи хэлний багш, англи хэлний орчуулагч, хэл шинжлэл хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэж байгаа нь тус мэргэжил зах зээлийн эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байгаа юм. Тус хөтөлбөрөөр төгссөн оюутнууд мэргэжлээрээ төдийгүй бусад байгууллагуудад ажиллах, ялангуяа орчуулагч, хөтөч тайлбарлагчаар ажиллаж байгаа нь тус мэргэжлийн хөрвөх чадвар өндөр байгааг харуулж байна. Үүнээс гадна төрийн болон хувийн их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт англи хэлний хичээлийг заавал болон сонгон судлах хичээл болгон орж байгаа бөгөөд энэхүү хандлага жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь гадаад хэлний мэргэжилтний хөдөлмөрийн зах

зээл хангалттай байгааг харуулж байна.

2018 оны Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаанд Англи хэлний багш мэргэжлийн ажиллах хүчний эрэлтийн тоо 2019 онд 130 байна гэсэн тоон үзүүлэлт гарсан байна.

Дэлхий дээр 1.75 тэр бум хүн буюу дэлхийн нийт хүн амын 4-ний 1 нь англи хэлээр ярьж байна. Английн олон улсын зөвлөлөөс гаргасан мэдээгээр 2020 он гэхэд 2 тэр бум хүн англи хэлээр ярина гэсэн урьдчилсан тооцоо байна. Иймд англи хэл нь дэлхийн нийт хүн амын 2 дахь хэл гэдэг нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байна. Монгол улсад хамгийн их эрэлтэй мэргэжлийн 7-д орчуулагч, тайлбарлагч болон англи хэлний багшийн эрэлт хэрэгцээ байна гэсэн албан ёсны тооцоо байна.

Яагаад энэ хөтөлбөрийг сонгох вэ?



Ямар ажлын байранд гарах боломжтой вэ?

- Төрийн болон төрийн бус өмчийн ЕБС, цэцэрлэг, Мэргэжлийн боловсролын сургууль, коллеж, их, дээд сургуулиудад багшлах
- Олон улсын бүх шатны боловсролын байгууллага болон сургалтын төвүүдэд багшлах
- Аялал жуулчлал, бизнесийн чиглэлийн байгууллагуудад ажиллах боломжтой
- Дотоодын болон гадаадын байгууллагуудад гадаад харилцааны ажилтан, орчуулагч
- Олон улсын төсөл, хөтөлбөрийн зохицуулагч, менежер
- Олон улсын зах зээлд ажиллах
- Олон улсын багш солилцооны хөтөлбөрөөр гадаадад багшлах
- Боловсролын байгууллагын гүйцэтгэх болон удирдах албан тушаал
- Судалгааны байгууллагуудад судлаач, шинжээч

Багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрийн судлах хичээл ба агуулга

№	Хичээл	Кредит	Судлах улирал	Хичээлийн агуулга
1	Философи	3	I	Онолын (метафизик, эпистемологи) ба практик (үнэлэмжийн) философийн үндсэн асуудлууд, гол гол баримтлалтай танилцаж ерөнхий мэдлэг олж авна. Энэ хичээлийг үзсэнээр бие даасан, шүүмжлэлт сэтгэлгээтэй болох, асуудлыг олон талаас нь авч үздэг байх, мэдээллээс зөв сонголт хийдэг байх, нэг асуудлаарх ялгаатай үзлүүдэд хүлээцтэй ханддаг байх, мэтгэлцэх тодорхой чадвар эзэмшинэ. Философи суурь асуудлуудыг дэвшүүлж, эргэцүүлснээр

				аливаа асуудлыг шийдвэрлэхдээ олон талаас нь ханддаг болоход тусална.
2	Монгол хэл бичиг, найруулга зүй	3	I	Хичээлээр дамжуулан оюутан монгол хэлний зөв бичих дүрэм, найруулга зүйн цогц хичээл, бичих чадвараа хөгжүүлэх аргууд, эх зохион бичих, албан бичгийн найруулга, Монгол бичгээр цэвэр, зөв, алдаагүй бичих зэрэг ойлголт, ур чадваруудыг суралцах болно.
3	Биеийн тамир	1	I	Оюутын биеийн ерөнхий хөгжил болон биеийн чанаруудыг /хурд, хүч, авхаалж самбаа, уян хатан, тэсвэр тэвчээр/ сайжруулах, хөдөлгөөний эвсэл, эв дүйг олгоход чиглэгдэнэ. Гимнастик, хөнгөн атлетик, сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, хөдөлгөөнд тоглоом, ахисан түвшний хичээлүүдийг энэхүү хичээлээр судална.
4	Англи хэл I	3	I	Англи хэлний анхан шатны түвшинд буюу A1-A2 түвшинд тодорхой сэдвийн хүрээнд унших, бичих, ярих, сонсох чадваруудыг эзэмших, англи хэлний хэлзүйн болон үг зүй, үгсийн сангийн анхан, анхан дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох ур чадвар олгох.
5	Дээд математик I	3	I	Энэхүү хичээл нь Нийгэм, хүмүүнлэг, хууль, эрх зүйн шинжлэх ухааны салбарт суралцаж амжилт гаргахад дэмжлэг болох математикийн суурь мэдлэгийн үндсийг өгөх, математик сэтгэлгээг хөгжүүлэх, математикийн гоо сайхан болон хэрэглээг таниулах зорилготой. Энэ хичээлээр ерөнхий боловсролын сургуульд үздэг нэг хувьсагчийн функцний дифференциал болон интеграл тоолол, аналитик геометрийн ойлголтуудыг дэлгэрүүлж, хоорондын уялдаа холбоог илүү тодруулж, практик хэрэглээний олон жишээний хамтаар үзнэ.
6	Мэдээллийн технологи, мэдээллийн систем I	3	I	Мэдээллийн технологи, мэдээллийн систем хичээлийн зорилго нь компьютерын технологийн хөгжлийг зохистой хэрэглэх, системийн орчинд ажиллан компьютерт үйлдлийн систем суулгаж сурах, шинэ шинэ техник технологийг судлах, танилцах, компьютерын бүтэц бүрэлдэхүүн, хэрэглээний програмуудтай ажиллаж сурах, компьютерын аюулгүй байдлыг сайжруулах, интернэтийн орчинд ажиллан мэдээллийг оновчтой хайлт хийн олж авах, веб технологиудыг судлах мэдлэг, ур чадваруудыг эзэмшинэ.
7	Монгол бичиг	2	I	Монгол бичгийн зөв бичих зүйн тулгуур зарчмыг хэлшинжлэлийн үндэстэй ухаарч, өдөр тутмын хэрэглээ болгох чадварыг олгох зорилгоор монгол бичгээр уншуулах, бичүүлэх, монгол бичгээс кирилл бичигт, кирилл бичгээс монгол бичигт хөрвүүлэх дасгалын аргад суурилж, энэ хичээлийг явуулна.
8	Соёл судлал	2	I	Соёлын тухай үндсэн ойлголт, түүний талаарх эрдэмтэн судлаачдын үзэл бодол, үзэл баримтлалтай танилцаж соёлын гол гол төлөөлөгчдийн амьдрал уран бүтээлд шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар өгөх цогц мэдлэг эзэмшинэ. Урлаг соёлын талаар явуулж байгаа төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэл бодлогын чиг хандлагыг мэддэг болно. Монголын төдийгүй, дэлхий дахины соёлын үнэт зүйлс, өвийн талаарх мэдлэгээ энэхүү хичээлийг үзсэний үндсэн дээр бусдад тайлбарлан таниулах чадвартай болно. Түүх дурсгалын эд зүйлс, соёл урлагийн хосгүй нандин дурсгалуудыг хайрлан хүндэтгэх үзэл, хүмүүжилтэй болно.
9	Оюуны өмчийн эрхзүй	2	I	Оюуны өмчийг эзэмшихэд бүрдүүлэх процессыг логик холбоо учир зүйн шалтгаан, стандарт, эрх зүйн үүднээс шат дараалан гүйцэтгэх чадвар, үр дүнг эзэмшүүлэх. Оюуны хөдөлмөр эрхлэгч, улмаар цаашдаа оюуны хөдөлмөр эрхлэх багш нарт энэ талын эрх зүйн мэдлэг, боловсрол олгох.
10	Логик	2	I	Аргументын /үндэслэгээний/ онол, бодомжийн логик, дедуктив логик, формаль биш логикийн онолын суурь мэдлэг эзэмшинэ. Цэгцтэй, дэс дараатай сэтгэх чадвар, унших, сонсох, ярих, бичихдээ алдаагүй, зөв дүгнэлт хийх чадвар, логикийн хууль, дүрмүүдийн шаардлагыг сахин биелүүлэх чадвар, формаль биш алдаануудаас зайлсхийх, үндэслэгээг зөв тавих чадвар, дедуктив оюун дүгнэлтийг хэлбэрчлэн томъёолж зөв, буруу хэлбэрүүдийг ялган тогтоох зэрэг тодорхой чадвар эзэмшинэ. Эргэцүүлэл дэх зөв бурууг ялгах, нотлох, няцаах зэрэгт зөв үндэслэл өгөх рациональ хандлага төлөвшинэ. Сэтгэхүйн үндсэн хэлбэрүүд, зөв сэтгэхүйн дүрмүүд, эргэцүүлэл дэх алдаануудын талаар судална.
11	Экологи байгаль, хамгаалал	2	I	Экологи, байгаль хамгааллын үндсэн ойлголт, ухагдахуун, чухал асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх арга зам, авч хэрэгжүүлж буй практик арга хэмжээнүүдийг зөвхөн өөрийн орны төдийгүй, дэлхий дахинаа олон улсын хэмжээнд өргөн цар хүрээтэй авч үзэх болно.
12	Физик	2	I	Физикийн хичээлээр механик хөдөлгөөн, дулаан, цахилгаан, молекул физик, оптик талаар онол арга зүйн мэдлэг чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.
13	Сэтгэл судлал I	2	I	Сэтгэл судлалын шинжлэх ухаан, түүний салбаруудын үүсэл, түүх, хөгжлийн үе шат, суурь парадигмууд, тэдгээрийн гол төлөөлөгчдийн онол, үзэл баримтлал; Хүний сэтгэл зүйн мөн чанар, сэтгэцийн физиологи үндэс, зан үйлийн биологи, социаль хүчин зүйлсийн зүй тогтол, харилцан хамаарал, хүний байгаль, нийгэмтэй харилцах зан үйл, түүний хэлбэрүүд, үр дагавар, зан үйлийн хэм хэмжээ зэргийн талаарх мэдлэг чадвар олгох.
14	Хэлний онол I	3	I	Англи хэлний авиа зүй, үг зүй, үгийн сан, утга судлал, өгүүлбэр зүйн онцлогийг судалж, үгсийн аймгийн талаарх мэдлэг эзэмшиж, хэлний онолын ойлголтод тулгуурлан судалгаа шинжилгээ хийх арга барил эзэмшинэ. Англи болон Монгол хэлний онолын мэдлэг дээр тулгуурлан олж авсан ерөнхий мэдлэгийг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ англи хэлний онолын мэдлэг чадвар, дадлыг

				интеграцитай системчилж, монгол хэлтэй зэрэгцүүлэн харьцуулж онол дадлагын үндсийг бүрдүүлэх зорилготой.
15	Монголын түүх, соёл, ёс заншил	3	II	Түүхэн үйл явдлыг тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал, гадаад дотоод шалтгаантай холбон задлан шинжлэх; Монголчуудын тусгаар тогтнолын төлөө тэмцэл, хөдөлгөөнүүдийг ач холбогдол, үр дагавар, түүхэн сургамжтай нь холбон өнгөрсөн, одоо, ирээдүйн залгамжаар тайлбарлах; Түүхэн зүтгэлтэн, газар нутаг, түүхэн цаг хугацаа, түүхэн үйл явдал, түүхэн сургамж, шалтгаан, үр дагаврыг холбон тайлбарлах мэдлэг, чадвар, дадлыг эзэмшинэ.
16	Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй	3	II	Хүний хөгжлийн тухай ойлголт, үзэл баримтлал, хүний чадавхад суурилсан хөгжлийн арга зам, хүний хөгжлийн хэмжүүрүүд, хөгжил дэх тэгш бус байдал, хүний аюулгүй байдал, хүний хөгжлийн төлөөх эдийн засгийн өсөлт, хүний хөгжлийн төлөөх макро болон микро түвшний бодлогууд, тэдгээрийн өвөрмөц байдлын талаар ойлголт, онолын мэдлэг эзэмшүүлнэ.
17	Гамшгийн менежмент	1	II	Гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал чухлаар тавигдаж буй өнөө үед нийт иргэдийн гамшгаас өөрсдийгөө болон бусдыг авран хамгаалах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, аюулгүй амьдрах соёлыг бий болгох нь тулгамдсан асуудлын нэг юм. Иймд Монгол Улсын "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого"-ын баримт бичигт "Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлэх, хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах, гамшгийн эмзэг байдлыг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил иргэдийн оролцоог хангах замаар улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.
18	Англи хэл II	3	II	Энэхүү хичээлээр Англи хэлний анхан дунд шатны түвшинд тодорхой сэдвийн хүрээнд англи хэлний хэл зүй болон ярианы орчин үеийн сургалтын идэвхтэй аргуудыг ашиглан унших, бичих ярианы болон сонсголын чадваруудыг сайжруулах, сонсож ойлгох ойлгосноо буцаан илэрхийлэх чадваруудыг эзэмшүүлэх, олон улсын англи хэлний түвшин тогтоох шалгалтад бэлтгэж, шалгалтын арга техникуудийг эзэмшүүлэх зорилготой. Энэхүү хичээлээр Англи хэлний энгийн өдөр тутам хэрэглэгдэх болон тухайн сэдвийн хүрээнд хэрэглэгдэх үг хэллэгүүдийг харилцан яриа, хөгжилтэй тоглоом, сонсгол, унших, дасгал ажиллах гэх мэт сургалтын идэвхтэй аргуудаар судлахаас гадна тухайн үг хэллэгийг өдөр тутмын амьдралд ашиглах, англи хэлээр дунд шатны түвшинд ярьж ойлгох, өөрийгөө болон бусад зүйлсийг илэрхийлэх чадвартай болгоход энэхүү хичээлийн зорилго оршино.
19	Дээд математик II	3	II	Дээд математик хичээлээр Хязгаар ба тасралтгүй чанар, Дифференциал тоолол, тодорхойгүй интеграл, тодорхой интеграл, Ердийн дифференциал, Тоон цуваан талаар онол арга зүйн мэдлэг чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.
20	Эрүүл мэнд, амьдрах ухаан	2	II	"Эрүүл мэнд, амьдрах ухаан" хичээлийн хөтөлбөр нь суралцагчдад эрүүл мэндийн тухай ерөнхий ойлголт өгөх, эрүүл аж төрөх чадвар, хандлагыг төлөвшүүлэхийн зэрэгцээ эрүүл мэндийн хичээлийг заах арга зүйд сургах зорилготой.
21	Япон хэл	2	II	JF стандарт буюу япон хэлний олон улсын боловсролын стандартын үндсэн чиг баримтлалд тулгуурлан, япон хэлний хоёр цагаан толгойн 96 үсгийн дуудлага, бичлэг, нийлэмж, тэмдэглэгээ, богино хэмжээний бичвэрийн өргөлт, утгын өргөлт, тоо, цаг хугацаа, төлөөний нэрийг зөв дуудаж, уншиж, хэрэглэж сурахаас гадна тэдгээрийг тэмдэглэх 45 орчим дүрс үсгийн унших, бичих, хэрэглэх аргыг сурна.
22	Солонгос хэл	2	II	Мэндлэх өөрийгөө танилцуулах, эд зүйлсийг нэрлэх, сургуулиа танилцуулах, өдөр тутмын амьдрал, дуртай зүйлийнхээ тухай ярих, огноо, гараг хэлж сурах, цаг хугацаа, өдрийн төлөвлөгөө хэлж сурах, өнгөрсөн явдлыг ярих, санал тавих, бараа худалдан авах, үнэ асуух, хүсч байгаа зүйлээ хэлэх, хоол захиалах, урих, байрлал зааж өгөх, гэр бүлээ танилцуулах, мэдээлэл солилцох, цаг агаар болон төлөвлөж буй ажлын тухай ярих, баяр хүргэх, хийж чадах зүйлээ ярих, айлчлах, хүн танилцуулах, мэдээлэл солилцох, цаг агаар болон төлөвлөж буй ажлын тухай ярих, утсаар ярих, санаа зорилгоо хэлэх, баяр хүргэх, учраа тайлбарлах, хийж чадах зүйлээ ярих, хоббигоо тайлбарлах, өдөр тутмын амьдрал, нийтийн тээврийн хэрэгсэл зэргээр харилцахад хэрэгтэй үгийн сан, хэлзүйн чадвартай болно.
23	Хятад хэл	2	II	Хятад хэлний үндэс I хичээлээр хятад хэлний авиа: эгшиг, гийгүүлэгч, хятад хэлний хөг, хөгийн хувирал, сул хөг, ханз үсэг, ханзны зурлага, дараалал, түлхүүр үсэг түүний утга, богино өгүүлбэр, байнга хэрэглэгдэх үг хэллэгийг эхлэн сонсгон, оюутан тус бүрийн ойлгож буй эсэх дээр багш ажиллаж, хүн нэг бүрт хандан харьцах ба амьд хэлээр ярьж буй хүний дохио зангаа, дуу авианы өөрчлөлт болох өгүүлбэрийн хэсгүүдийн өндөрсөх ба намсах гэх мэт хүний ярианы өнгөөр илрэх сэтгэл хөдлөлийн энгийн жишээг сонсох, цаашлан богино өгүүлбэрээр ярих харилцан яриа сонсох, хоорондоо адилавар дуудлагатай жишээг сонсох, хятад хэлний хөг ярианы явцад хэрхэн хувиран өөрчлөгддөг зэргийг зааж, бичлэг сонсгон дагаж унших, давтан хэлэх, цээжлэх, бусдын мэндчилгээнд хариулах, хүсэлтээ илэрхийлэх, мөн өөрийн санаа бодлоо илэрхийлэх, цаашлаад зураг дүрс харан ярих тухайн хэлийг судалж байгаа оюутнуудад багш тухайн орны соёл зарим соёлын ялгаа онцлогийг тайлбарлан,

				оюутныг тухайн хэлээр сэтгэх үйл явцад аажмаар дасгах зэрэг болно .
24	Орос хэл	2	II	Монгол улсын хойд хөрш бөгөөд Дэлхийн тэргүүлэх гүрний нэг ОХУ-ын хэлийг ярих, сонсох, унших, бичих үндсэн дөрвөн чадварт тулгуурлан ТРКИ I түвшний мэдлэг, чадварыг оюутан сурагчдад олгож, эзэмшүүлэхээс гадна нийгэм, улс төр, хууль эрх зүй болон эзэмшиж буй мэргэжилд холбогдох зохиол уншиж ойлгох, орос хэл дээрх мэдээллийн эх сурвалжаас шаардлагатай мэдээлэл авах зохих түвшний чадвартай болгоход энэ хөтөлбөрийн зорилго оршино.
25	Эдийн засгийн онолын үндэс	2	II	Тухайн хичээлээр оюутнуудад ханш уналт, ажилгүйдэл, мөнгөний зах зээл, нийт эрэлт, нийлүүлэлт, эдийн засгийн өсөлт, хуримтлал, зээлийн хүүгийн түвшин, хөрөнгө оруулалт, орлого, хэрэглээ, хадгаламжийн талаар онол, арга зүйн цэгцтэй мэдлэг, практикт үр дүнтэй ашиглах чадварыг эзэмшүүлэх зорилготой.
26	Менежментийн үндэс	2	II	Энэхүү хичээлээр менежментийн тухай ойлголт, байгууллагын орчин, төлөвлөлт, байгууллагын менежмент, манлайлал, менежментийн харилцаа, хүний нөөцийн удирдлага, стратегийн удирдлагын тухай ойлголтуудыг авч үзнэ.
27	Социологи	2	II	“Социологи: Нийгмийн бодит байдлыг шинжлэхүй” хэмээх хичээлийн агуулгын хүрээнд оюутан, тус шинжлэх ухааныг бусдаас ялгаруулж байдаг, социологийн шинжилгээний гол объект, судлагдхуун болсон Нийгмийн бодит байдлын дараахь бүлэг асуудлуудтай танилцах болно. Үүнд: – социологийн үүсэл, хөгжил, судлах зүйл ба Социологийн анализын онцлог – хүний нийгмийн хамтын амьдрал, нийгмийн бүтэц ба соёлын онцлог, бүлэг ба нийгэм, бие хүн ба нийгэмшил, – гэр бүл, боловсрол, шашин, засаглал, эдийн засаг зэрэг нийгмийн институт, – ялгарал ба давхраажил, нийгмийн гаж үзэгдэл ба гэмт хэрэг, – даяаршил, мэдээллийн технологийн дэвшил ба орчин үеийн нийгмийн өөрчлөлт, – социологийн онол, судалгааны арга, аргачлал хийгээд түүний практик хэрэглээ
28	Нийгмийн газар зүй	2	II	Нийгэм-эдийн засгийн газарзүйн ерөнхий ойлголт, Хөгжлийн газарзүй, Хүн амын газарзүй, Соёлын газарзүй, Хотын газарзүй, Байгалийн нөөцийн газарзүй, Үйлдвэрлэлийн газарзүй, Үйлдвэрлэлийн анхдагч салбарын газарзүй, Үйлдвэрлэлийн хоёрдогч салбарын газарзүй, Үйлдвэрлэлийн гурав ба дөрөвдөгч салбарын газарзүй, Байгаль-нийгмийн тулгамдсан асуудлууд, тогтвортой хөгжлийн талаар судална.
29	Бүтээлч сэтгэлгээ	2	II	Эргэн санах, сэтгэлгээ буюу сэтгэн бодох үйл ажиллагаа, бүтээлч сэтгэлгээ, бүтээлч сэтгэлгээ ба шүүмжит сэтгэлгээ, бүтээлч хүн, сэтгэлгээний олон талт хэлбэрүүд, тэдгээрийг хөгжүүлэх арга барилд суралцана.
30	Хэлний онол II	3	II	Англи хэлний авиа зүй, үг зүй, үгийн сан, утга судлал, өгүүлбэр зүйн онцлогийг судалж, үгсийн аймгийн талаарх мэдлэг эзэмшиж, хэлний онолын ойлголтод тулгуурлан судалгаа шинжилгээ хийх арга барил эзэмшинэ. Англи болон Монгол хэлний онолын мэдлэг дээр тулгуурлан олж авсан ерөнхий мэдлэгийг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ англи хэлний онолын мэдлэг чадвар, дадлыг интеграцчилан системчилж, монгол хэлтэй зэрэгцүүлэн харьцуулж онол дадлагын үндсийг бүрдүүлэх зорилготой. Англи хэлний үг, үг зүйн дүрэм, өгүүлбэр, өгүүлбэр зүйн дүрэм, гишүүн өгүүлбэр, түүний бүтэц, төрөл, бүрэлдэхүүн, өгүүлбэрийн төрөл ангиллын тухай мэдлэг, чадвар, хандлагыг олгоход энэхүү хичээлийн зорилго оршино.
31	Судалгаа шинжилгээний арга зүй	3	III	Шинжлэх ухаан тэр дундаа судалгаа шинжилгээний арга ухаанд суралцах, судалгаа гэж юу болох судалгааны төрөл ангилал, арга хэрэгсэл, судалгаа шинжилгээ хийх шат дараалал, судалгааны ажилд тавигдах шаардлагууд, судлаач хүнд байх ёстой мэдлэг, ур чадвар, судалгааны програмуудыг судлах, аливаа зүйлийг судлан танин мэдэх, өөрийн мэргэжлээр судалгааны ажил хийж сурах, ирээдүйн судалгааны чиг баримжаатай болох. Шинжлэх ухаан, судалгааны тухай ойлголт, хөгжлийн үе шат Шинжлэх ухааны мэдлэг, мэдлэгийг бүтээлчээр ашиглах Судалгаа, түүний талаар нэгдсэн ойлголттой болох Судалгааны бүтэц, тавигдах шаардлагыг эзэмших Судлаачийн ёс зүй, арга барилыг эзэмших Судалгааны төрөл ангиллыг мэдэх Судалгааны аргууд, тэдгээрийн онцлог Судалгааны хэрэгсэл, програмуудыг танин мэдэх, эзэмших, Судалгааны асуулга, анкет боловсруулах Цахим асуулга, анкет боловсруулах Судалгаанд оролцогчид, тэдгээрийг сонгох арга Судалгааны үр дүн боловсруулах Судалгааны дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах Судалгаа шинжилгээ хийж сурах
32	Боловсрол судлал	3	III	Боловсролын олон талт асуудлыг судлах боломжит судалгааны арга, аргачлалтай танилцаж, түүнийгээ практикт хэрэглэж, бие хүний хөгжил төлөвшил, түүний үндсэн чиглэлийг судлан танин мэдэх, сурган хүмүүжүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах мэдлэг чадвар, дадлыг эзэмшинэ. Боловсрол судлал нь бие хүний хөгжих, төлөвших, боловсрох үйл явцын мөн чанар, зүй тогтол, агуулга арга зүй, зохион байгуулалтын асуудлыг

				боловсролын бусад (боловсролын философи, боловсролын түүх, боловсролын социологи, эрх зүй гэх мэт) асуудалтай нь иж бүрэн тогтолцоонд судалдаг ухаан юм. Бие хүний хөгжил, боловсрол, төлөвшилийн мөн чанар, зүй тогтол, үндсэн хууль зарчмыг нь судлан боловсруулж, бие хүн өөрийн сурч боловсрох, хүмүүжих ажлаа шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад чиглэнэ.
33	Сурган хүмүүжүүлэх зүй	3	III	Сурган хүмүүжүүлэх зүйн үүсэл, хөгжил, хандлага, зорилго судлах зүйл болон сурган хүмүүжүүлэх үйл явц, түүнийг зохион байгуулах арга зүй, түүнийг танин мэдэх хэрэгцээ ба сурах арга, боловсролын тусгай хэрэгцээт хүүхэд, хүмүүжил, түүний онол арга зүй, бие хүний хөгжил төлөвшил, боловсрол тэдгээрийн холбоо хамаарал, эцэг эх асран хамгаалагчидтай ажиллах арга зүй, багшийн ажлын үнэлгээ, багшийн хөгжил, сургалтын агуулга арга зүй, зэргийг удирдан зохион байгуулах мэдлэг дадал эзэмшүүлэхэд оршино.
34	Сэтгэл судлал II	3	III	Сэтгэл судлалын шинжлэх ухаан, түүний салбаруудын үүсэл, түүх, хөгжлийн үе шат, суурь парадигмууд, тэдгээрийн гол төлөөлөгчдийн онол, үзэл баримтлал; Хүний сэтгэл зүйн мөн чанар, сэтгэцийн физиологи үндэс, зан үйлийн биологи, социал хүчин зүйлсийн зүй тогтол, харилцан хамаарал, хүний байгаль, нийгэмтэй харилцах зан үйл, түүний хэлбэрүүд, үр дагавар, зан үйлийн хэм хэмжээ зэргийн талаарх мэдлэг чадвар олгох.
35	Хэлний онол III	2	III	Англи хэлний утга зүй, хэл шинжлэл, нийгэм, нөлөөллийн утга, үг, өгүүлбэрийн утга, хэлний утга, ижил, эсрэг утгатай үгс, зүйрлэл, үгсийн сан, утгын үүрэг, дүрмийн харилцааны тухай, өгүүлбэрээс дээших хэлний хэрэглээ, ярианы утга, илтгэл, өдөр тутмын амьдрал дахь хэлний хэрэглээ зэргийг судлах ба мэргэжлийн үр чадвар, хандлага эзэмших.
36	Англи хэлний яриа бичгийн дадлага (Анхан шат III)	4	III	Англи хэлний анхан дунд шатны түвшинд буюу A2-B1, B2 түвшинд тодорхой сэдвийн хүрээнд унших, бичих, ярих, сонсох чадваруудыг эзэмших, англи хэлний хэлзүйн болон үг зүй, үгсийн сангийн анхан, анхан дунд, дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох үр чадварт суралцуулах нь энэхүү хичээлийн зорилго юм.
37	Сургалтын онол, арга зүй	2	IV	Сурган хүмүүжүүлэх хичээлүүд, сурган хүмүүжүүлэх ёс зүй, анги удирдах урлаг, монголчуудын хүүхдээ хүмүүжүүлэх уламжлал, ардын сурган хүмүүжүүлэх ухаан, хүүхдийг хүмүүжүүлэх төлөвшүүлэх арга ухаан, гэр бүлийн хүмүүжил, хайрлах энэрэх сэтгэлээр хүмүүжүүлэх, монгол ардын ухаан, хүүхдийн хөгжил төлөвшилд бие хүний төлөвшил, хөгжил, багш мэргэжил, багшийн сэтгэл зүйн онцлог багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа анги удирдсан багш харилцааны соёл, хөгжил зэргийг төлөвлөж зохион байгуулах мэдлэг дадал эзэмшүүлэхэд оршино.
38	Хэлний онол IV	2	IV	Хэл ба тархи, хэлний өөр өөр функцүүд, хэлний өөрчлөлт, хэлний өөрчлөлтийн шалтгаан, төрлүүд, дуу авианы өөрчлөлт, утгын өөрчлөлт, хэл аялгуу, нутгийн аялгууны үгсийн өөрчлөлт, үндэс угсааны хэлний өөрчлөлт зэргийн талаар мэдлэг, чадвар хандлага эзэмших.
39	Хэл шинжлэлийн удиртгал	2	IV	Төрөлх хэл эзэмших, хоёрдогч хэлийг эзэмших үйл явц, хөгжлийн үйл явц, дараалал, заах арга барил, тооцооллын хэл шинжлэл, хэл эзэмших зарчим, хэлний хэрэглээ, харьцуулсан хэл шинжлэл, хэлзүйн онолын тухай мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлэх.
40	Бизнесийн англи хэл	2	IV	Энэхүү хичээлийн судалснаар оюутнууд өдөр тутмын болон бизнесийн орчинд бичгийн болоод ярианы хэлийг Англи хэлийг дунд түвшний хэмжээнд хэрэглэх өөрийгөө бусдад тодорхой хэмжээнд ойлгуулж танилцуулах, бусдыг ойлгох чадвартай болно. Энэхүү хичээлээр оюутнууд бизнестэй холбоотой үг хэллэг, хэлц, өөрийгөө танилцуулах, бусдад илэрхийлэх, өөрийн намтрыг бичиж, ярих, хурал уулзалтын үеэр хэрэглэгдэх үг хэллэгийг сурах, өөрийгөө бусдад ойлгуулах, албан бичиг баримтыг англи хэл дээр боловсруулах, албан захиа явуулах, орчуулах, ажлын ярилцлагад бэлдэх, утсаар ярих, үр дүнтэй илтгэл буюу презентаци бэлдэх гэх мэт мэдлэгийг Англи хэл дээр эзэмших.
41	Англи-Америк орон судлал	2	IV	Англи-Америк орон судлал хичээл нь англи хэлний мэргэжлийн ангийн оюутнуудад Америкийн соёл, ёс заншил, өв уламжлал, түүх, нийгмийн байдал, газар нутаг, бэлэг тэмдэг, онцлог, олон улсын харилцаа, тэмдэглэлт баяр ёслол, арга хэмжээ, хүмүүсийн аж амьдралын талаар мэдлэг олгох тухайн улсын соёлыг судалж танилцахад чиглэгдэнэ.
42	Мэргэжлийн дидактик I	3	IV	Мэргэжлийн дидактик нь тухайн боловсролын стандартыг хэрэгжүүлэх дидактикийн цогц чадамжийг эзэмшүүлэх, төлөвшүүлж хөгжүүлэхэд чиглэсэн, өөрийн уян хатан тогтолцоо бүхий судлагдахуун юм. Суралцагчид тухайн мэргэжлийн дидактикийн мэдлэгийг сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн интеграци түвшинд эзэмших, бүтээлчээр хэрэглэх, хамтран ажиллах чадвар, багшийн цогц чадамжийг төлөвшүүлж, хөгжүүлэхэд чиглэгдэнэ.
43	Англи хэлний яриа бичгийн дадлага (Дунд шат I)	4	IV	Англи хэлний дунд шатны түвшинд буюу B1-B2 түвшинд тодорхой сэдвийн хүрээнд унших, бичих, ярих, сонсох чадваруудыг эзэмших, англи хэлний хэлзүйн болон үг зүй, үгсийн сангийн анхан, анхан дунд, дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох үр чадварт суралцуулах нь энэхүү хичээлийн зорилго юм.
44	Орчуулгын онол	2	IV	Орчуулга болон орчуулгын онолын үндсэн ухагдахуун, Монгол болон гадаад хэлний өгүүлбэрийн байгууламж, найруулга зүйн онцлог, түүнийг харгалзан орчуулах арга, орчуулгад хэрэглэгдэх практик арга барилууд, мөн өмнө

				хэвлэгдэн гарч олны хүртээл болсон чадварлаг орчуулагчдын бүтээл, орчуулгын ажлын өнөөгийн байдал, орчуулгын арга зүй, тулгамдсан асуудал зэрэгтэй танилцсанаар орчуулга хийх суурь мэдлэгтэй болно
45	Англи хэлний орчуулга I	2	IV	Энэхүү хичээл нь мэргэжлийн ангийн оюутнуудад Англи хэлний орчуулгын анхан шатны мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилготой бөгөөд Англи хэлнээс Монгол хэл рүү үг, өгүүлбэр, эх, материалыг орчуулж буулгах ур чадвар эзэмшүүлэх зорилготой. Үүнээс гадна орчуулгын арга барил, ур чадвар эзэмших, орчуулгын төрөл хэлбэр, орчуулгын дүйцэл, орчуулагчийн анхаарах зүйл, орчуулгын ёс зүй, орчуулгын үед анхаарах зүйлс зэргийг эзэмшүүлэх зорилготой.
46	Цахим сургалтын арга зүй	2	V	1. Сургалтын агуулга боловсруулах 2. Moodle.org дээр онлайн курс үүсгэх, системийн тохиргоо хийх 3. Сургалтын материалыг хянах, шинэчлэх 4. Гарын авлага болон бусад нэмэлт материалуудыг цахим ном хэлбэрт шилжүүлэх 5. Сургалтын презентациудыг шинэчлэх 6. Сургалтын лекц, хичээлүүдийг видео лекц хэлбэрт хөрвүүлэх 7. Сургалтын материал, хичээлүүдийг онлайн курсын системд байршуулах 8. Онлайн курсын ажиллагааг шалгах, бэлэн байдлыг хангах
47	Хөтөлбөр судлал	2	V	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, нэгж хичээлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй, тэдгээрийн ялгаа, агуулга, тавигдах шаардлага, хөтөлбөрийн ач холбогдол, хөтөлбөрийн хүрэх ур дүн, хичээлийн бүрдэл, тараах материал, үзүүлэн зэргийг боловсруулах арга зүй зэрэг мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлэх.
48	Мэргэжлийн дидактик II	3	V	Мэргэжлийн дидактик нь тухайн боловсролын стандартыг хэрэгжүүлэх дидактикийн цогц чадамжийг эзэмшүүлэх, төлөвшүүлж хөгжүүлэхэд чиглэсэн, өөрийн уян хатан тогтолцоо бүхий судлагдахуун юм. Сургалтын бүтээлч аргуудыг хэрэглэж сурагч төвтэй сургалтыг зохион байгуулах арга барилтай боловсон хүчин бэлдэх. Багш мэргэжлийн ёс зүйг дагаж мөрдөх. Англи хэлний хичээлийн үе шатуудыг зөв хуваарилах, сурагчдын унших, ярих, бичих, сонсох чадваруудыг хөгжүүлэх бүтээлч аргуудыг хэрэглэж сурагч төвтэй сургалтыг зохион байгуулах арга барилтай болгох, ээлжит болон нэгж хичээлийн хөтөлбөрийг сурах бичиг, сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан боловсруулах чадвар эзэмшүүлэх. Англи хэл заах арга, зарчим, англи хэлний хичээлийн онцлог, бүтэц, зохион байгуулалт, унших, бичих, яриа, сонсголын хичээлүүдийг заах арга зүй, зарчим, холбогдох ажил даалгаврууд, гадаад хэлний боловсролын стандарт, нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүй, сурагчдыг болон өөрийгөө үнэлэх үнэлгээ, хичээлээс гадуур зохиогдох ажил, анги удирдах ажлуудыг бие дааж гүйцэтгэх мэдлэгтэй болно.
49	Англи хэлний яриа бичгийн дадлага (Дунд шат II)	4	V	Англи хэлний дунд болон ахисан дунд шатны буюу B1-B2 түвшинд тодорхой сэдвийн хүрээнд ярих, сонсох чадваруудыг эзэмших, англи хэлний ярианы болон үг зүй, үгсийн сангийн дунд түвшний мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох ур чадварт суралцуулах нь энэхүү хичээлийн зорилго юм. Мөн эзэмшиж буй мэргэжлийн хүрээнд англи хэлийг дунд шатны түвшинд орчин үеийн дэвшилтэт арга хэрэгслүүдийг ашиглан ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар заах, тайлбарлах ур чадваруудад суралцах. Англи хэлний дунд болон ахисан дунд шатны буюу B1-B2 түвшинд тодорхой сэдвийн хүрээнд унших, бичих чадваруудыг эзэмших, англи хэлний хэлзүйн болон үг зүй, үгсийн сангийн дунд түвшний мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох ур чадварт суралцуулах нь энэхүү хичээлийн зорилго юм. Мөн эзэмшиж буй мэргэжлийн хүрээнд англи хэлийг дунд шатны түвшинд орчин үеийн дэвшилтэт арга хэрэгслүүдийг ашиглан ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар заах, тайлбарлах ур чадваруудад суралцах.
50	Англи хэлний орчуулга II	2	V	Энэхүү хичээл нь мэргэжлийн ангийн оюутнуудад Монгол хэлнээс Англи хэл рүү орчуулах чадвар эзэмшүүлэх зорилго бүхий хичээл бөгөөд тодорхой сэдвийн хүрээнд орчуулгын дасгал хийж орчуулгын дүйцүүлэх, утгачлах, орхих, нэмэх гэсэн орчуулгын аргуудыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ. Мэргэжлийн ангийн оюутнуудын хувьд өөрийн төрөлх хэлнээс судалж буй хэл рүү аливаа зүйлийг орчуулан буулгах нь суурь чадваруудын нэг бөгөөд орчуулах арга барилаа олж цаашид бие даан орчуулга хийх нь энэхүү хичээлийг зайлшгүй судлах шаардлага юм.
51	Ангийн ажил /Англи хэл/	1	V	Англи хэлний ангийн ажил хичээл нь англи хэлний багш мэргэжлийн ангийн оюутнуудад мэргэжлийн чиг баримжаа олгох, өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу судалгаа шинжилгээний ажил, хийж багшийн мэргэжлийн чиглэлийн дагуу өөрийгөө хөгжүүлэх, цаашлаад судалгааны ажил хийж, англи хэл судалж буй суралцагчид, зааж буй багш сурган хүмүүжүүлэгчид, англи хэлний сургалтын талаар харьцуулалт, үнэлэлт дүгнэлт хийх, өөрийн заах арга ур чадварыг сайжруулах, заах арга барилаа олж авах зэрэг олон ур чадваруудыг эзэмшинэ. Оюутанд хичээлээр олж авсан мэдлэгээ бататгаж, бодит амьдралд хэрэглэх чадвар эзэмшүүлэх. Англи хэлний заах арга зүй, болон англи хэлний боловсрол, монгол англи хэлний талаарх асуудлуудыг олон талаас нь шинжлэн судалж, нэгтгэн дүгнэлт өгөх чадвар эзэмшүүлэх. Англи хэлний боловсролын талаар судалгааны материалуудыг уншиж судлах

				Судалгааны ажлын сэдвээ сонгох Сонгосон сэдвийн дагуу дагуу судалгааны материалуудыг уншиж судлах Судалгааны зорилго зорилт, үндэслэлээ дэвшүүлэх Судалгааны ажлаа бичих Судалгааны ажлаа хамгаалах
52	Англи-Америк уран зохиол	2	V	Британийн уран зохиол, Америкийн уран зохиол хоёулаа дэлхийн уран зохиолын салшгүй хэсэг юм. Англо-Америкийн уран зохиолын аль ч үед тэд дэлхийн улс төр, соёл, түүх, тэр байтугай ард түмний амьдралд чухал нөлөө үзүүлсэн. Англо-Америкийн уран зохиол нь урт удаан жилийн түүхтэй бөгөөд үүссэн цагаасаа хойш өөрчлөгдөн хөгжиж ирсэн. Энэ нь янз бүрийн түүхэн цаг үед өөр өөр хэв маягийг харуулдаг. Дэлхийн уран зохиолын сан хөмрөгийг баяжуулж буй агуу зохиолчид, уран бүтээлүүд тасралтгүй гарч ирж байна. Уг хичээлээр Англи-Америкийн уран зохиолын түүхэн хөгжлийг судлан, англи уран зохиол ба Америкийн уран зохиолын янз бүрийн төрөл, хэв маягийг нэгтгэн танилцуулах.
53	Албан бичиг боловсруулах арга зүй	2	V	Онол болон практик үйл ажиллагаанд тулгуурлан баримт бичгүүдийг стандартын дагуу боловсруулах арга зүйг эзэмшүүлэхэд оршино. Удирдлагын ажлыг хөнгөн шуурхай болгох, баримтжуулах, баримт бичгийг хуулийн хүчинтэй байлгах, албан хэрэг хөтлөх соёлыг хэвшүүлэх Баримт бичгийн нэр төрлийн онцлогийг ангилан, ялган тайлбарлах Баримт бичгийн бүрдэлд стандартыг мөрдөх Хэвлэмэл хуудсыг стандартын дагуу хэрэглэх Баримт бичгийг стандартын дагуу компьютерт боловсруулах Албан хэрэг хөтлөх үйл ажиллагаанд дүрэм, журам, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах Бие даан бүтээлчээр сэтгэх, системтэйгээр төлөвлөх, судлан шинжлэх аргагүйг ашиглах, асуудалд шүүмжит сэтгэлгээгээр хандах Баг бүрдүүлэн ажиллаж удирдлагын олон талт асуудлыг шийдвэрлэх
54	Англи-Монгол зэрэгцүүлсэн хэл зүй	2	VI	Англи хэлний онцлог, Монгол хэлний онцлог, хэлзүйн ялгаа, дүрэм, англи-Монгол хэлний ижил ба ялгаатай дүрмүүдийг тайлбарлах, дүн шинжилгээ хийх, хэл шинжлэлийн хэв шинжийг тодорхойлох мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох үр чадварт суралцуулах нь энэхүү хичээлийн зорилго юм.
55	Англи хэлний яриа бичгийн дадлага (Дунд шат III)	4	VI	Англи хэлний дунд болон ахисан дунд шатны буюу B1-B2 түвшинд тодорхой сэдвийн хүрээнд ярих, сонсох чадваруудыг эзэмших, англи хэлний ярианы болон үг зүй, үгсийн сангийн дунд түвшний мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох үр чадварт суралцуулах нь энэхүү хичээлийн зорилго юм. Мөн эзэмшиж буй мэргэжлийн хүрээнд англи хэлийг дунд шатны түвшинд орчин үеийн дэвшилтэт арга хэрэгслүүдийг ашиглан ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар заах, тайлбарлах үр чадваруудад суралцах.
56	Англи хэлний орчуулга III	2	VI	Энэхүү хичээлээр Англи хэлнээс Монгол хэл рүү, Монгол хэлнээс Англи хэл рүү орчуулах арга барилуудыг судалж эзэмших, орчуулах чадварт суралцах, өгүүлбэрийн бүтцүүдийг харьцуулж, дүйцүүлэх, утгачлах, Албан бичиг, бичиг баримт боловсруулах сэдвийн хүрээнд үгсийн санг баяжуулан, өөрийн болгож, тухайн сэдвийг англи хэлэнд буулгах чадвартай болгоход энэхүү хичээлийн зорилго оршино.
57	Англи хэлний зохион бичлэг	1	VI	Англи хэлний зохион бичлэг хичээл нь зохион бичих эрдэмд суралцах, зохион бичлэг, эсээний төрөл ангиллыг судлах, төрөл тус бүр дээр зохион бичих арга барил эзэмшүүлэх, англи хэлний дунд, ахисан дунд шатны түвшинд англи хэлний дүрэм, өгүүлбэрийн бүтэц, өгүүлбэрийн гишүүдийн дараалал, үгсийн аймаг, үгсийн аймгийн онцлог, зохион бичлэг бичих дүрэм дараалал, мэргэжлийн эсээ бичих заавар, эсээний бүтэц, эсээнд тавих шаардлага, өгүүлбэрийн төрөл ангилал, холбоос үгсийг ашиглах зэрэг мэргэжлийн онол, үр чадварыг олгоно.
58	Ангийн ажил /Боловсрол судлал/	1	VI	Ангийн ажлын үндсэн зорилго нь оюутан сонгосон сэдвийнхээ дагуу суралцсан хугацаандаа эзэмшсэн онолын мэдлэгээ бататган өргөжүүлж судалгаа шинжилгээ хийх арга зүй, чадвар, дадлыг олгоход оршино.
59	Сурган хүмүүжүүлэх дадлага	2	VI	<ul style="list-style-type: none"> Оюутан бүр дадлагын хугацаанд ажлаа төлөвлөж дараах хүснэгтийг бөглөж, эсвэл загварын дагуу тусад нь үйлдэж ЕБС-ийн удирдсан багшаар батлуулж ажиллана. Оюутан дадлагын хугацаанд дүнтэй 4 цаг, дүнгүй 8 цагийн хичээл заана. Дүнтэй цагийн хичээлийн үнэлгээг дадлагын дэвтэр дээрх зориулалтын хүснэгтэд бичүүлнэ. Оюутан заах хичээлийн бэлтгэлийг 3-аас доошгүй хоногийн өмнө хангаж, нэгж хичээлийн болон ээлжит хичээлийн хөтөлбөрөө 2 хоногийн өмнө дадлага хийж буй сургуулийнхаа Сургалтын менежер, ЗАН-ын багш эсвэл ЕБС-ийн удирдсан багшаар батлуулна. Дадлага хийх хугацаанд дааж авсан ангийнхаа 1 сурагчийг сурган, сэтгэл зүйн судалгаа хийж тодорхойлолт гаргана. Дадлага хийж буй оюутнууд доод тал нь 5 багш нарын хичээлд сууж тэмдэглэл хөтөлнө. Суусан болон заасан хичээлдээ дүн шинжилгээ хийнэ.

				<ul style="list-style-type: none"> • Анги удирдсан багшид тусалж ажиллана. • Дадлагын үед хийсэн ажлаа өгсөн хүснэгтэд тэмдэглэл хөтөлж үнэлүүлнэ.
60	Албан бичгийн орчуулга	2	VI	Албан бичгийн орчуулга хичээл нь албан байгууллага, албан ажил, бизнесийн болон хувь хүний баримт бичигтэй холбогдон гарах албан бичиг бүхий баримт бичгүүдийг орчуулах эрдэмд суралцах чадварыг олгоход чиглэгдсэн ба орчуулгын дүйцэл, орчуулах арга барил, Монгол англи хэлний дүйцэл, орчуулгын зарчим, англи хэлний болон монгол хэлний ялгаа, онцлог, англи хэлний өгүүлбэр, түүний бүтэц ангилал, Монгол хэлний өгүүлбэрийн бүтэц, ангиллын талаар онолын мэдлэгийг олгох, мөн орчуулгын дасгал хийж эдгээрийг эзэмших, орчуулга хийх чадварыг бий болгоход чиглэгдэнэ.
61	Сургалтын цахим хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй	2	VI	Мэдээлэл харилцаа, холбооны технологийг хэрэглэн сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, сургалтдаа ашиглах, сургалтын интерактив цахим хэрэглэгдэхүүн боловсруулах программ хангамжуудыг судлах, хэрэглэх асуудал бүх мэргэжлийн багш нарын өмнө тулгараад байгаа тул цахим сургалтын талаар сурган хүмүүжүүлэгч мэргэжлийн ангид тусгайлан орж хичээлийн хэрэглэгдэхүүнийг баяжуулах, бэлтгэх аргазүйг эзэмшүүлэхэд чиглэсэн.
62	Англи хэлний яриа бичгийн дадлага (Дээд шат I)	4	VII	Англи хэлний ахисан шатны түвшинд буюу C1-C2 түвшинд тодорхой сэдвийн хүрээнд унших, бичих, ярих, сонсох чадваруудыг эзэмших, англи хэлний хэлзүйн болон үг зүй, үгсийн сангийн анхан, анхан дунд, дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох ур чадварт суралцуулах нь энэхүү хичээлийн зорилго юм.
63	Багшлах дадлага I	3	VII	<ul style="list-style-type: none"> • Оюутан бүр дадлагын хугацаанд ажлаа төлөвлөж дараах хүснэгтийг бөглөж, эсвэл загварын дагуу тусад нь үйлдэж ЕБС-ийн удирдсан багшаар батлуулж ажиллана. • Оюутан дадлагын хугацаанд дүнтэй 4 цаг, дүнгүй 12 цагийн хичээл заана. Дүнтэй цагийн хичээлийн үнэлгээг дадлагын дэвтэр дээрх зориулалтын хүснэгтэд бичүүлнэ. • Оюутан заах хичээлийн бэлтгэлийг 3-аас доошгүй хоногийн өмнө хангаж, нэгж хичээлийн болон ээлжит хичээлийн хөтөлбөрөө 2 хоногийг өмнө Дадлага хийж буй сургуулийнхаа Сургалтын менежер, ЗАН-ын багш эсвэл ЕБС-ийн удирдсан багшаар батлуулна. • Дадлага хийх хугацаанд дааж авсан ангийнхаа 2-оос доошгүй сурагчийн сурган, сэтгэл зүйн судалгаа хийж тодорхойлолт гаргана. • Дадлага хийж буй оюутнууд хичээлд сууж тэмдэглэл хөтөлнө. • Суусан болон заасан хичээлдээ дүн шинжилгээ хийнэ. • Анги удирдсан багшид тусалж ажиллана. • Дадлагын үед хийсэн ажлаа өгсөн хүснэгтэд тэмдэглэл хөтөлж үнэлүүлнэ.
64	Аман орчуулга	2	VII	Энэхүү хичээлээр Англи хэлний Аман орчуулга болон бичгийн орчуулга тэдгээрийн ялгаа, хооронд нь харьцуулах, орчуулгын тодорхой орчинд орчуулга хийх (жишээ нь хурал дээр эмнэлэг дээр гэх мэт), синхрон орчуулга, дамжуулах орчуулга гэх мэт аман орчуулгын төрлүүд тэдгээрийг хэрэглэх, аман орчуулгын багаж хэрэгслийг ашиглаж сургах үндсэн зорилготой. Оюутнуудад англи хэлний заах аргын орчин үеийн хөгжүүлэх аргууд, сонсгол, бичлэг, зураг, биет үзүүлэн гэх мэт материалуудыг ашиглан өөрийгөө илэрхийлэх, англи хэлний ахисан шатны түвшинд сонсож ойлгох дасгалуудыг ажиллах Англи хэлний сургалтын идэвхтэй аргууд, англи хэлний яриа, англи хэлний сонсголын талаарх ном, сурах бичиг, гарын авлагуудыг уншиж судлан, хичээлийн агуулга, ерөнхий бүтэц, төлөвлөгөө, лекц, семинарыг боловсруулах Тодорхой орчин, нөхцөлд Аман орчуулга хийх дасгал ажлуудыг ажиллах Цахим эх сурвалж ашиглан, хичээлийн хэрэглэгдэхүүн, үзүүлэн таниулах материал, бичлэг, дүрс зэргийг бэлтгэх
65	Англи хэлний яриа бичгийн дадлага (Дээд шат II)	4	VIII	Англи хэлний ахисан шатны түвшинд буюу C1-C2 түвшинд тодорхой сэдвийн хүрээнд унших, бичих, ярих, сонсох чадваруудыг эзэмших, англи хэлний хэлзүйн болон үг зүй, үгсийн сангийн анхан, анхан дунд, дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдыг ойлгох ур чадварт суралцуулах нь энэхүү хичээлийн зорилго юм.
66	Багшлах дадлага II	3	VIII	<ul style="list-style-type: none"> • Багшлах дадлагаар мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд голлон анхаарна. • Оюутан бүр дадлагын хугацаанд хийх ажлаа төлөвлөж дараах хүснэгтийг бөглөж, эсвэл загварын дагуу тусад нь үйлдэж сургалтын менежер, удирдсан багшаар батлуулж ажиллана. • Дүнтэй 4 цаг, дүнгүй 16 цаг, нийт 20 цагийн хичээл заахаас гадна онолын мэдлэгээ практик үйл ажиллагаандаа хэрэглэн багшлах арга барил, эв дүй эзэмшихэд нөөц бололцоогоо дайчлан ажиллана. Хичээлийн үнэлгээг дадлагын дэвтэр дээрх зориулалтын хүснэгтэд бичүүлнэ.

				<ul style="list-style-type: none">• Заах хичээлийн бэлтгэлийг 3-аас доошгүй хоногийн өмнө хангаж, нэгж хичээлийн болон ээлжит хичээлийн хөтөлбөрөө 2 хоногийн өмнө ЕБС-ийн сургалтын менежер, ЗАН-ийн дарга эсвэл удирдсан багшаар батлуулна.• Бусад багшийн хичээлд суун дүн шинжилгээ хийж, сурган хүмүүжүүлэх тэмдэглэл хөтөлнө.• Нэг баг болон дадлага хийж буй оюутнуудын хичээлд сууж тэмдэглэл хөтөлнө. Хичээлд хамтарч бэлтгэнэ. Хичээлийн үр дүнг хэлэлцэнэ.• Заасан хичээл, явуулсан ажилдаа өөрөө дүгнэлт хийж арга барилаа сайжруулах талаар тэмдэглэл хөтөлнө.• Анги удирдан ажиллана. 2-оос доошгүй сурагчийн сурган, сэтгэл зүйн судалгаа хийж тодорхойлолт гаргана.• Сургуулиас зохион байгуулж буй ажилд идэвхтэй оролцож тэмдэглэл хөтөлж, өөрөө үнэлгээ өгнө.• Аль нэг сэдвээр бие дааж сурган хүмүүжүүлэх ажиглалт судалгаа хийнэ.• Дадлагын хугацаанд зохиосон ажлуудаа ЕБС-ийн дадлага удирдсан багш, сургалтын менежерээр үнэлүүлнэ.
--	--	--	--	--

БАГШ, МЭДЭЭЛЭЛ ЗҮЙН БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨР

Их дээд сургуульд мэдээлэл технологийн багш, Ерөнхий боловсролын сургуульд мэдээлэлзүйн багш, байгууллагуудад мэдээлэл технологийн инженер хийх боломжтой

Мэргэжлийн давуу тал

Мэдээлэл зүйн багш мэргэжлийн давуу тал нь сургууль боловсролын бүх байгууллага, түүний дотор ерөнхий боловсролын сургуулийн түвшинд мэдээлэл зүйн /информатик/ сургалтыг дэлхий нийтийн боловсролын чиг хандлагатай уялдуулан зохион байгуулж, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа явуулах мэдлэг чадвар бүхий, аль ч байгууллага болон боловсролын салбарт ажиллах боловсон хүчин болдогоороо давуу юм.

Эзэмших мэдлэг

Боловсрол судлал, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх зүйн ухаан, сургуулийн мэдээлэл зүйн боловсролын орчин үеийн чиг хандлагыг баримтлан, мэргэжлийн дидактик хичээлээр эзэмшсэн арга зүйгээ ашиглах замаар мэдээлэл зүйн сургалтыг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах, төрөл бүрийн бүтэц бүхий алгоритм-програмыг зохиох, орчин үеийн програмчлалын арга, объект хандалтат сэтгэлгээгээр интернет, дотоод сүлжээ болон тухайн системийн орчинд ажиллах, програм бичих, веб хуудас үүсгэх, тэдгээрийг хөгжүүлэх, шинээр гарч буй технологийг бие даан эзэмшихэд шаардлагатай сүлжээ, түүний шинжилгээг хийж ашиглах зэрэг компьютерийн ухааны суурь мэдлэгтэй байна.

Эзэмших ур чадвар

Боловсролын бүх шатанд мэдээлэл зүйн хичээлийг зохион байгуулах эв дүйгээс гадна сургалтын технологийн шинэчлэлийг тусгасан дэвшилтэт арга зүй бүхий ээлжит хичээл төлөвлөлтөнд тусган хэрэгжүүлэх, мэдээлэл харилцааны технологийг сургалтын үйл ажиллагаанд хэрэглэх, сургуулийн мэдээлэл зүйн боловсролын агуулгыг тухайн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, тусган баяжуулах чадвар эзэмших.

Эзэмших програм

Хэрэглээний програм хангамж word, excel, powerpoint, зургийн paint програм, програмчлалын хэл C, C++, java, вэб хийх HTML хэл, Dreamweaver програм, мультимедиа flash програм, PHP, Access, SQL програмчлалын хэл болон програмуудыг судлаж мэдсэн байна.

Онцлог

Мэдээлэлзүй болон мэдээллийн технологийн хичээлийг явуулахад шаардлагатай онолын болон практик мэдлэг, чадварыг эзэмшиж, сурган хүмүүжүүлэх үйл явцыг төлөвлөн зохион байгуулах, сургалтандаа сургалтын идэвхтэй аргуудыг ашиглах, мэргэжлийн түвшиний програмуудыг судлан, сүлжээний орчинд чөлөөтэй ажиллах чадвартай мэдээлэл технологийн мэргэжилтэн болдог.

Ажлын байрны эрэлт

Эрэлттэй ажлын байрны тэргүүнд орж байна. Боловсролын салбарт мэдээлэлзүйн багш болон бусад байгууллагуудад мэдээлэл технологийн инженер, болон сүлжээний инженер хийх боломжтой.

БАГШ, БАГА БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨР

Төрийн болон төрийн бус өмчийн сургуульд багшаар ажиллах боломжтой.

Мэргэжлийн давуу тал

- Хүүхэд бүрийн насны онцлогт тохирсон сургалтыг явуулах мэдлэг эзэмших
- Хичээлийг заах арга, ур чадварт суралцах
- Сургалтыг үр дүнтэй явуулах олон аргуудаас суралцах
- Хүүхэдтэй ажиллах арга барилаас суралцах
- Танилцах, Цагаан толгойн, Багшлах дадлагыг 5-аас дээш жил мэргэжлээрэй ажилсан туршлагатай багш дээр хийх
- Дадлагын ажлаараа тайлан хамгаалж гарын авлага гаргах
- Өөрийн мэргэжлийн чиглэлээр судалгаа шинжилгээ болон, дипломын ажил хамгаалах, илтгэл, эссе бичих

Эзэмших мэдлэг

- БББ-ын түвшний мэдлэг
- Заах арга, ур чадвар
- Сурган хүмүүжүүлэх арга ухаан
- Сэтгэл судлал, боловсрол судлал
- Багшийн мэргэжил ур чадвараа дээшлүүлэх
- Харилцан мэдээлэл, туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлэх
- Багшийн ажлыг удирдан зохион байгуулах, ёс зүй сахилга бат харилцааны соёлд суралцах
- Хүүхдүүдтэй харилцах арга барил, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, нээн илрүүлэх
- Хүүхдийн насны онцлогт тохируулан сургалтыг явуулах, авъяасыг нээн илрүүлэх
- Хүүхдийн хөгжил болон арга зүйн чиглэлээр судалгаа хийх
- Хүүхэд хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөх
- Эцэг эх хүүхдийн хамтын ажиллагааг сайжруулах

Эзэмших ур чадвар

- Сургалтын хөтөлбөрийг боловсруулж сурах
- Хэл яриа, математикийн энгийн төсөөлөл төлөвшүүлэх, байгаль орчин, дүрслэн урлахуй, хөдөлгөөн эрүүл мэндийн хичээлийг заах арга, ур чадварыг эзэмших
- Цагийг баримталж, өдрийн дэглэмийн дагуу ажиллах
- Багаар ажиллах чадвартай байх
- Интернэт орчинд ажиллах
- Хүүхдийн нэг бүрийг хөгжил, төлөвшил, хоцрогдол, хэл ярианы, болон бие бялдарын, оюун санааны хөгжил, эрүүл мэндийн байдал, зэргийг сайтар ажиглан ажиглалтын тэмдэглэл хөтлөлт хийх
- Насны онцлогт нь тохирсон сургалтыг явуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн явц дутуу хүүхдийг гадуурхахгүй байх
- Хүүхдийг хайрлаж, урамшуулж, урам өгч сургаж хүмүүжүүлэх
- Хүүхдийн хөгжих боломжийг нээн төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах
- Интернэт орчинд ажиллах

Эзэмших програм

- Ексел болон word программ дээр ажиллах
- MS office програм
- Google classroom аппликешн

Онцлог

- Бага боловсролын багш мэргэжлээр суралцан төгссөн оюутан нь заах арга барил, ур чадвар, багшлах арга барил эзэмшсэн бөгөөд төгсөөд ажлын байранд гарах боломж нээлттэй эрэл хэрэгцээ ихтэй мэргэжил юм. Мөн энэхүү мэргэжлээр төгссөн оюутан цэцэрлэгийн багш мэргэжлээр ажиллах, арга зүйч багш, эрхлэгч мэргэжлээр хөрвөж ажиллах боломжтой.

Бага ангид янз бүрийн шашин шүтлэгтэй гэр бүлд өссөн, янз бүрийн насны, мөн хөгжлийн түвшин нь харилцан адилгүй хүүхдүүд хамтран амьдарч, суралцаж, тоглодог. Бусадтай харилцах харилцаагаа туршиж үзэх боломжтой тийм өвөрмөц нийгэмшихүйн онцлог орчин сургууль юм.

БАГШ, СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨР

Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгт багшаар ажиллах боломжтой.

Мэргэжлийн давуу тал

- Хүүхэд бүрийн насны онцлогт тохирсон сургалтыг явуулах мэдлэг эзэмших
- Хичээлийг заах арга, ур чадварт суралцах
- Сургалтыг үр дүнтэй явуулах олон аргуудаас суралцах
- Хүүхэдтэй ажиллах арга барилаас суралцах
- Багшлах дадлага, цэцэрлэг дээр 3 удаа хийх
- Дадлагын ажлаараа тайлан хамгаалж гарын авлага гаргах
- Өөрийн мэргэжлийн чиглэлээр судалгаа шинжилгээ болон, дипломын ажил хамгаалах, илтгэл, эссе бичих

Эзэмших мэдлэг

- СӨБ-ын түвшний мэдлэг
- Заах арга, ур чадвар
- Сурган хүмүүжүүлэх арга ухаан
- Сэтгэл судлал, боловсрол судлал
- Багшийн мэргэжил ур чадвараа дээшлүүлэх
- Харилцан мэдээлэл, туршлага солилцдог, өөрсдийгөө хөгжүүлэх
- Багшийн ажлыг удирдан зохион байгуулах, ёс зүй сахилга бат харилцааны соёлд суралцах
- Хүүхдүүдтэй харилцах арга барил, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, нээн илрүүлэх
- Хүүхдийн насны онцлогт тохируулан сургалтыг явуулах, авъяасыг нээн илрүүлэх
- Хүүхдийн хөгжил болон арга зүйн чиглэлээр судалгаа хийх
- Хүүхэд хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөх
- Эцэг эх хүүхдийн хамтын ажиллагааг сайжруулах

Эзэмших ур чадвар

- Сургалтын хөтөлбөрийг боловсруулж сурах

- Хэл яриа, математикийн энгийн төсөөлөл төлөвшүүлэх, байгаль орчин, дүрслэн урлахуй, хөдөлгөөн эрүүл мэндийн хичээлийг заах арга, ур чадварыг эзэмших
- Цагийг баримталж , өдрийн дэглэмийн дагуу ажиллах
- Багаар ажиллах чадвартай байх
- Интернет орчинд ажиллах
- Хүүхдийн нэг бүрийг хөгжил, төлөвшил, хоцрогдол, хэл ярианы, болон бие бялдарын, оюун санааны хөгжил, эрүүл мэндийн байдал, зэргийг сайтар ажиглан ажиглалтын тэмдэглэл хөтлөлт хийх
- Насны онцлогт нь тохирсон сургалтыг явуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн явц дутуу хүүхдийг гадуурхахгүй байх
- Хүүхдийг хайрлаж, урамшуулж, урам өгч сургаж хүмүүжүүлэх
- Хүүхдийн хөгжих боломжийг нээн төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах
- Интернет орчинд ажиллах

Эзэмших програм

- Ексел болон word программ дээр ажиллах
- MS office програм
- Google classroom аппликешн

Онцлог

- Сургуулийн өмнөх боловсролын багш мэргэжлээр суралцан төгссөн оюутан нь заах арга барил, ур чадвар, багшлах арга барил эзэмшсэн бөгөөд төгсөөд ажлын байранд гарах боломж нээлттэй эрэл хэрэгцээ ихтэй мэргэжил юм. Мөн энэхүү мэргэжлээр төгссөн оюутан цэцэрлэгийн багш мэргэжлээр ажиллах, арга зүйч багш, эрхлэгч мэргэжлээр хөрвөж ажиллах боломжтой.

Цэцэрлэгт янз бүрийн шашин шүтлэгтэй гэр бүлд өссөн, янз бүрийн насны, мөн хөгжлийн түвшин нь харилцан адилгүй хүүхдүүд хамтран амьдарч, суралцаж, тоглодог. Бусадтай харилцах харилцаагаа туршиж үзэх боломжтой тийм өвөрмөц нийгэмшихүйн онцлог орчин цэцэрлэг юм.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨТӨЛБӨР

Энэхүү мэргэжлээр Аялал жуулчлалын салбарт олон улсын болон бүс нутаг, орон нутгийн түвшний байгаль нийгэм-соёл, эдийн засгийн нөөцүүдийг илрүүлэх, бүс нутгийн эдийн засаг, байгаль орчин, нийгэм соёлын ялгаатай төлөв, тогтвортой хөгжлийн зарчмуудад үндэслэсэн бодлого боловсруулж төрөл бүрийн нөлөөллийн судалгааг хийх, тэдгээрийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэглэгчийн зан төлөвт уялдуулан, олон улсын болоод бүс нутгийн зах зээл, өрсөлдөөний орчны шинжилгээ, судалгааны үр дүнг ашиглах, газарзүй, нийгэм, эдийн засгийн онол, суурь зарчмуудыг аялал жуулчлалын хөгжлийг судлах, бодлого боловсруулах, бизнесийн салбарт ажиллана. Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбар, үйлчилгээний байгууллагын хэрэглэгч, зах зээл, өрсөлдөөний орчны шинжилгээ, судалгааны үр дүнг ашиглах, менежментийн онол, практик жишээ, зарчим, аргуудыг ашиглан бизнесийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, өрсөлдөх чадварыг сайжруулах мэргэжлийн болон ёс зүйн хариуцлагатай ажиллах, бүтээгдэхүүн үйлчилгээний шинэ санаа, шийдвэр гаргах, тулгамдсан асуудлыг шийдэх гарцыг олох чадвар эзэмших, түүнийг боловсруулах, хөгжүүлэх, байгууллагыг алсын хараатай удирдах зэрэг ерөнхий чадамжтай болно. Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах чадвар, аялал жуулчлалын байгууллагын болон салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг үнэлэх, дүгнэх, бодлого, төлөвлөгөө боловсруулах, удирдан зохион байгуулах чадвар эзэмшин, тоон шинжилгээний арга зүйг шийдвэр гаргалтдаа ашиглах, мэргэжлийн болон хэрэглээний програм хангамжийг ашиглах арга зүйд суралцана. Мөн гадаад хэлээр өөрийн салбар хийгээд бусад салбар чиглэлүүдийг жуулчдад бүрэн гүйцэд ойлгуулах, ярилцах, хамтран ажиллах чадварыг эзэмшинэ

ЭЗЭМШИХ МЭДЛЭГ:

Аялал жуулчлал хөтөлбөрөөр төгсөгчид нь аялал жуулчлалын үйл ажиллагааг эрхлэн явуулах, газарзүйн нөхцөл, аялал жуулчлалын нөөц боломж дээр тулгуурлан байгаль, газар зүй, аялал жуулчлалын бүс нутаг, түүх соёлын талаар шинжлэн судалж, хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах аялал жуулчлалын байгууллагын болон салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг үнэлэх, дүгнэх, бодлого, төлөвлөгөө боловсруулах, удирдан зохион байгуулах чадвар, тоон шинжилгээний арга зүйг шийдвэр гаргалтдаа ашиглах, бизнесийн ашиг орлогыг нэмэгдүүлэх бодлого боловсруулах, орчин үеийн мэдээллийн технологит суурилсан хэрэглээний програм хангамжийг насан туршдаа ашиглах ур чадвар эзэмшүүлнэ.

ЭЗЭМШИХ УР ЧАДВАР:

эзэмшсэн аялал жуулчлалын болон бусад шинжлэх ухааны мэдлэгээ ашиглан салбарын тулгамдсан асуудлуудыг шийдэх, аливаа асуудалд мэргэжлийн сэтгэл зүйгээр шинжлэх ухаанчаар хандах дадал чадвар эзэмшүүлнэ.

Зорилт 2: Аялал жуулчлал хөтөлбөрөөр төгсөгчид нь өөрийгөө хөгжүүлэх, шинийг эрэлхийлэх, бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх, бие даан мэдлэг, ур чадвараа тасралтгүй сайжруулах дадал, хандлагыг төлөвшүүлнэ.

Зорилт 3: Аялал жуулчлал хөтөлбөрөөр төгсөгчид нь харилцааны өндөр соёлтой, хамт олны итгэл хүндлэл хүлээх чадвар, мэргэжлийн ёс зүйтэй болж салбарын хэмжээнд үнэлэгдэх, эерэг хандлагатай, хүмүүсийн үзэл бодол, итгэл үнэмшилд хүндэтгэлтэй ханддаг, шударга ёсыг эрхэмлэдэг, хувь хүний болон мэргэжлийн өндөр хариуцлага, ёс суртахуунтай, бусдад үлгэрлэх, багаар ажиллах, харилцах, хамтран суралцах чадвар эзэмшүүлнэ.

КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гранд тур клубийн зорилго нь: Аялал жуулчлал хөтөлбөрөөр төгсөгчид нь харилцааны өндөр соёлтой, хамт олны итгэл хүндлэл хүлээх чадвар, мэргэжлийн ёс зүйтэй болж салбарын хэмжээнд үнэлэгдэх, эерэг хандлагатай, хүмүүсийн үзэл бодол, итгэл үнэмшилд хүндэтгэлтэй ханддаг, шударга ёсыг эрхэмлэдэг, хувь хүний болон мэргэжлийн өндөр хариуцлага, ёс суртахуунтай, бусдад үлгэрлэх, багаар ажиллах, харилцах, хамтран суралцах чадвар эзэмшүүлнэ.

МЭРГЭЖЛИЙН ДАВУУ ТАЛ

Сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбараас нийт 54,000 мянган ажлын байр бий болгосон

нь дотоодын нийт ажлын байрны 4,8%-ийг бүрдүүлжээ. 2016 онд аялал жуулчлалын салбараас бий болгосон нийт ажлын байрны тоо 7,2%-иар өсөж 58,000 хүрсэн нь дотоодын нийт ажлын байрны 4,9%-ийг бүрдүүлж байна. Цаашид аялал жуулчлалын салбараас бий болгох ажлын байрны тоо ирэх 10 жилд тогтмол өсөх бөгөөд 2026 он гэхэд 79,000 хүрч, дотоодын нийт ажлын байрны 6,2 хувийг бүрдүүлэх төлөвтэй байна. Энэ нь уг хөтөлбөрөөр суралцан төгсөөд шууд ажлын байранд гарах боломжийг нэмэгдүүлж байна. Сүүлийн жилүүдэд дэлхий нийтийг хамарсан цар тахал зэргээс шалтгаалан жуулчдын зорих газар ихээхэн өөрчлөгдөж томоохон хотуудыг зорихоос илүүтэйгээр байгаль руу чиглэсэн сонголт нэмэгдэж байгаа нь байгалийн аялал жуулчлал голлон хөгжсөн Монгол улсын хувьд давуу тал болж уг мэргэжлийн эрэлтийг нэмэгдүүлж байна. Монгол улсын хэмжээнд 20 гаруй их, дээд сургуулиуд Аялал жуулчлалын чиглэлээр сургалт явуулж буй бөгөөд тус сургууль нь 2001 оноос хойш тасралтгүй элсэлт авч салбарын тэргүүлэх мэргэжилтнүүдийг бэлтгэсээр байна.

АЖЛЫН БАЙРНЫ ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ

Аялал жуулчлал хөтөлбөрөөр төгссөн мэргэжилтнүүд дараах ажлын байранд ажиллах бүрэн боломжтой. Үүнд:

- Аялал жуулчлалын бизнесийн байгууллага, тур оператор, тур агентийн менежер, мэргэжилтэн
- БОАЖЯ, хот, аймаг сумдын аялал жуулчлалын газарт мэргэжилтэн, албаны дарга
- Зочид буудлын менежер, буудлын захиалгын менежер
- Ресторан, зоогийн газрын менежер, зохион байгуулагч
- Амралт сувиллын газар, жуулчны баазын менежер, зохион байгуулагч
- Аяллын хөтөч тайлбарлагч
- Энтертаймент, шоу бизнес, эвент менежер
- Үйлчилгээний байгууллагын удирдах ажилтан, менежер
- Музейн хөтөч, тайлбарлагч

ЭЗЭМШИХ ПРОГРАМ

Аялал жуулчлал хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд дараах програмуудыг судална.

- Бүх төрлийн захиалгын програм
- Сمارт баланс лайт санхүүгийн програм
- SPSS судалгааны програм
- Stata статистикийн програм
- Click up захиалгын програм

Эдгээр програмуудыг эзэмшсэнээр аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын бизнесийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх, үйлчилгээний технологийг аялал жуулчлалын мэдээллийн системд тулгуурлан өөрийн үйл ажиллагаандаа хэрэглэх чадвартай байна.